

МОНГОЛ УЛС  
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ  
ХОРОО

**ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН**  
**2010**

Vertical line



Санхүүгийн зохицуулах хороо 2010 оны үйл ажиллагааны тайлангаа Танд өргөн барьж байна.

2010 он бол Санхүүгийн зохицуулах хороо байгуулагдсаны 5 жилийн ой тохиож буй жил билээ. Жил жилийн үйл ажиллагааны тайлангаа олон нийтэд танилцуулж ирснээс хойш 5 дахь жилийнхээ тайланг танилцуулж байгаадаа таатай байна. Энэ 5 жилийн хугацаанд бидний авч хэрэгжүүлсэн бүхий л арга хэмжээ, явуулсан үйл ажиллагаа маань санхүүгийн зах зээлийн тогтвортой байдлыг хангах, санхүүгийн салбарын эрх зүйн орчныг боловсронгуй болгох, санхүүгийн зах зээлийн зохицуулалтын оновчтой чиг хандлагыг тодорхойлох, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах, хөрөнгө оруулагч үйлчлүүлэгчдийн хүсэлт, гомдлыг хууль тогтоомжийн дагуу хянан шийдвэрлэх, тэдний эрх ашгийг хамгаалах зэрэг зорилго, зорилтуудыг хангахад чиглэж байсан билээ.

Зохицуулалтын хүрээний санхүүгийн салбарын эрх зүйн орчныг шинэчлэн сайжруулж салбарын гол хуулиудыг шинэчлэх ажлыг 2009 оноос эхэлсэн хэдий ч 2010 онд хараахан тэмүүлсэн зорилгодоо хүрээгүй байна. 2011 онд энэ чиглэлд бид томоохон ахиц дэвшил гаргана гэдэгтээ итгэлтэй байна.

Манай улсын эдийн засаг, санхүүгийн зах зээл бусад улс орны эдийн засаг, санхүүгийн салбартай улам бүр холбогдож байгаа болон санхүүгийн зах зээл дотооддоо ч харилцан бие биенээсээ хамааралтай болсоор байгаа энэ үед санхүүгийн нэгдсэн зохицуулалт, хяналт шалгалтын тогтолцоо зайлшгүй юм. Энэ үүднээс Санхүүгийн зохицуулах хорооны зохицуулалтын хүрээ, хамаарах асуудлууд улам бүр нэмэгдсээр байна. Цаашид ч энэ хандлага үргэлжилсээр байх нь тодорхой юм. Иймд шинээр хорооны чиг үүрэгт хамаардаг болсон санхүүгийн асуудлуудын зохицуулалт хяналтад онцгой анхаарч, энэ чиглэлд баримтлах төрийн бодлогыг тодорхойлох ажлуудыг угтан ирж буй он жилүүдэд хийж гүйцэтгэх болно.

Хүндэтгэсэн,

Д.Баярсайхан

A handwritten signature in black ink, appearing to be the name 'D. Bayarsaikhan' written in a cursive style.

Санхүүгийн зохицуулах хорооны дарга

## САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ 2010 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

### НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

Санхүүгийн Зохицуулах Хороо нь 2010 онд үнэт цаас, даатгал, бичил санхүүгийн зах зээлийн эрх зүйн орчныг боловсронгуй болгох, мэдээллийн ил тод байдлыг хангах замаар компанийн засаглалын зарчмуудыг нэвтрүүлэх, Хорооны мэдээллийн технологийн хөгжлийг шинэ шатанд гаргах зорилт тавин ажиллалаа.

Санхүүгийн зохицуулах хороо 470 асуудлыг 14 удаагийн ээлжит хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэж, 434 тогтоол, 10 тэмдэглэл гаргасан бөгөөд энэ нь өнгөрсөн онтой харьцуулахад 2 дахин өссөн байна. Хорооны нэг удаагийн хуралдаанд дунджаар 33 асуудал хэлэлцсэн байна.

Хороо нь тайлант онд нийт 10083 бичгийн эргэлттэй байснаас хороонд ирсэн албан бичиг 6292, хорооноос гадагш явуулсан албан бичиг 3401, зохицуулалтын салбарын үйл ажиллагаатай холбоотой 391 өргөдөл, гомдол бүртгэгдэж шийдвэрлэгдсэн байна.

Хорооны Ажлын алба нь Үнэт цаасны газар, Даатгалын газар, Бичил санхүүгийн газар, Санхүүгийн тайлагнал, аудит, үнэлгээний чанарын хяналтын газар, Тамгын газар, Эрх зүйн хэлтэс, Хамтын ажиллагааны хэлтэс, Мэдээлэл технологийн хэлтэс, Дотоод хяналтын алба гэсэн бүтэцтэй ажиллалаа.


### ХОЁР. ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН ТАЛААР

#### 2.1. Үнэт цаасны зах зээлийн өнөөгийн байдал

2010 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар Монголын хөрөнгийн бирж дээр нийт 253 удаагийн арилжаа явагдаж, 136 компанийн 64,500,000.0 ширхэг хувьцааг 62.9 тэрбум төгрөгөөр, 3,000 ширхэг Засгийн газрын энгийн бондыг 30.0 тэрбум төгрөгөөр тус тус арилжиж нийт 92.9 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий гүйлгээ хийгдэж өнгөрсөн онтой харьцуулахад 4 дахин өссөн үзүүлэлттэй байна.

2010 онд Монголын хөрөнгийн биржээр арилжаалагдсан нийт хувьцаат компаниудын үнэт цааснаас 101 ХК-ийн үнэт цаасны ханш өсч, 22 ХК-ийн үнэт цаасны ханш буурч, 13 ХК-ийн үнэт цаасны ханш харьцангуй тогтмол байлаа.

**Үнэт цаасны арилжааны үнийн /тэрбум төгрөг/**




### Үнэт цаасны арилжааны үнийн дүн /тэрбум төгрөг /




Зах зээлийн үнэлгээ өмнөх оны эцэст 620.7 тэрбум төгрөг байсан бол 2010 оны эцэст 1 их наяд 373.9 сая төгрөгт хүрч өмнөх оноос даруй 2 дахин өссөн үзүүлэлтэй байна. Энэ нь уул уурхайн салбарын компаниудын хувьцааны ханш их хэмжээгээр өссөнтэй холбоотой юм.

### Зах зээлийн үнэлгээ /тэрбум төгрөг/




2010 оны жилийн эцсийн байдлаар хамгийн өндөр зах зээлийн үнэлгээтэй хувьцаат компаниудыг графикаар үзүүлбэл дараахь байдалтай байна.

### Зах зээлийн үнэлгээ өндөртэй хувьцаат компаниуд /тэрбум төгрөг/



Хөрөнгийн зах зээл дээр бүртгэлтэй хамгийн өндөр зах зээлийн үнэлгээтэй, хамгийн өндөр хөрвөх чадвартай 20 компанийн ерөнхий хандлагыг харуулж буй ТОП-20 индекс 2010 оны жилийн эцсээр 14,759.81 нэгж болсон нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 8,569.9 нэгжээр буюу 2.4 дахин өссөн үзүүлэлттэй байна.

### Топ – 20 индекс



#### 2.1.1 Зах зээлийн мэргэжлийн оролцогч байгууллагуудын талаар

2010 оны байдлаар Хөрөнгийн зах зээл дээр арилжаа эрхлэх байгууллага 1, үнэт цаасны төлбөр тооцоо, хадгаламжийн байгууллага 1, брокер, дилерийн 50 компани, нийтэд үнэт цаасаа санал болгон гаргасан 336 ХК үйл ажиллагаа явуулж байна.

Хороо тайлант жилд брокер дилерийн 3 компанид брокер, дилер, андеррайтер, хөрөнгө оруулалтын зөвлөхийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл шинээр олгож, 5 компанид хөрөнгө оруулалтын зөвлөхийн үйл ажиллагааны төрлийг нэмж, 2 компаний андеррайтерийн үйл ажиллагааг хүчингүй болгож, 3 компаний тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэн, 24 компанийн тусгай зөвшөөрлийг сунгаж, 1 компанийн тусгай зөвшөөрлийг хүчингүй болгожээ.

## Мэргэжлийн оролцогч байгууллага



Брокер, дилерийн 10 ХХК-иудын дүрмийн сангийн хэмжээ, бүтэц, хувь нийлүүлэгчдийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай хүсэлтийг хянан шийдвэрлэсэн байна.

Санхүүгийн тайланд үндэслэн зах зээлийн оролцогчдын үйл ажиллагааны үндсэн үзүүлэлтэд дүн шинжилгээ хийж ажиллаа. Энэ ажиллагаанд нийт 143 ХК, 50 мэргэжлийн байгууллагын санхүүгийн тайлан нэгтгэгдэж, 50 мэргэжлийн байгууллагад тайлангийн хариу явууллаа.

Тайлант хугацаанд хөрөнгийн зах зээл дээр үйл ажиллагаа явуулж буй мэргэжлийн байгууллагууд нийт 7.4 тэрбум төгрөгийн орлого олж, 6.3 тэрбум төгрөгийн зарлага гаргаж, нийт дүнгээрээ 1.1 тэрбум төгрөгийн ашигтай ажиллажээ.

2010 онд үнэт цаасны төлбөр тооцоо, төвлөрсөн хадгаламжийн төвийн 1,620 харилцагчийн дансанд 3,886 удаагийн 391.1 тэрбум төгрөгийн орлогын гүйлгээ, 9,585 харилцагчийн данснаас 12,865 удаагийн гүйлгээгээр 385.1 тэрбум төгрөгийн зарлагын гүйлгээ хийгдсэн байгаа бөгөөд 2009 оныхоос 1,539 хувиар өссөн байна.

Мөн 2010 оны дунд үеэс эхлэн үнэт цаасны арилжааны идэвхи сайжирч, нийт зах зээлийн хэмжээнд хувьцааны ханш аажмаар өссөн ба ялангуяа уул уурхайн салбарын компаниудын хувьцааны ханш огцом өссөнтэй холбоотойгоор нийт системийн байгууллагуудын ашигт ажиллагааны түвшин нэмэгдсэн байна.

Мэргэжлийн байгууллагуудын нийт орлогын 84.2 хувийг Монголын хөрөнгийн бирж, Үнэт цаасны төлбөр тооцоо, төвлөрсөн хадгаламжийн төв, Эм Ай Си Си, Глобал Ассет, Евроазиа капитал, Би Ди Сек, Фронтинер, Азиа Пасифик секьюритиес зэрэг компаниуд бүрдүүлсэн байна.

Тайлант онд хөрөнгийн зах зээлийн мэргэжлийн байгууллагуудын нийт капиталын хэмжээ 34.1 тэрбум төгрөг байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 12.8 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн үзүүлэлттэй байна.

Нийт капиталын 58.1 хувь брокер, дилерийн компаниудад оногдож байгаа бол “Монголын хөрөнгийн бирж”, “Үнэт цаасны төлбөр тооцоо, төвлөрсөн хадгаламжийн төв” гэсэн төрийн өмчит 2 компани үлдсэн 41.9 хувь буюу 14.3 тэрбум төгрөгийн капиталыг эзэмшиж байна.

Тайлант онд 230 гаруй иргэдийн хөрөнгийг харилцагчийн зөвшөөрөлгүй захиран зарцуулсан гэсэн өргөдөл гомдол гарчээ. Үүний дагуу өргөдөл, гомдлын мөрөөр зохих шалгалтыг хийж

захиргааны журмаар 20 гаруй харилцагчийн 2,716 хувьцаа болон 432,000 төгрөгийг дансанд буцаан байршуулж гомдлыг барагдууллаа.

“Үнэт цаасны төлбөр тооцоо төвлөрсөн хадгаламжийн төв” /ҮЦТТХТ/ ХХК-д 2010 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар нийт 450,077 үндсэн данс, 105,826 холболтын данс нээгдсэн.

Харин ХОЭБ-ийн санд бүртгэлтэй нийт 843,192 харилцагч данс нээлгэхээс 86.97 хувь буюу 109,848 харилцагч дансаа нээлгээгүй байна.

2010 онд шинээр 1085 дотоодын иргэн, хуулийн этгээд, 225 гадаадын иргэн, хуулийн этгээд, 4846 ХОЭБ-ийн данс нээгджээ.


Өмнөх онтой харьцуулбал монгол иргэдийн данс нээгдсэн байдал 1,9 дахин, гадаад иргэдийн данс 2,7 дахин өссөн бол хуулийн этгээдийн дансны хувьд дотоодын хуулийн этгээдийн данс 184 хувиар, гадаадын хуулийн этгээдийн данс 255.5 хувиар өссөн байгаа нь Монголын хөрөнгийн зах зээлд хөрөнгө оруулалт хийх гадны байгууллага, иргэдийн сонирхол өсч байгааг харуулж байна.

	Дансны төрөл			Харилцагчийн төрөл				Нийт	Холболт
	Шинэ	ХОЭБ	Хүсэлт	Иргэн		ААН			
				Монгол	Гадаад	Монгол	Гадаад		
2006	2304	9693	4215	16158	32	18	4	16212	2020
2007	50221	6372	14207	70434	324	25	17	70800	4449
2008	2654	2907	16170	21538	121	50	22	21731	3512
2009	671	491	7749	8803	74	25	9	8911	1086
2010	1310	1185	3661	5885	202	46	23	6156	3528

### 2.1.2. Хувьцаат компаниудын талаар

Тайлант хугацаанд хөрөнгийн зах зээл дээр бүртгэлтэй нийт 336 хувьцаат компаниас 16 компани 30.85 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий ногдол ашгийг тараасан бөгөөд өнгөрсөн онтой харьцуулахад тараасан ногдол ашгийн үнийн дүн 2 дахин өссөн үзүүлэлтэй байна.

**Ногдол ашиг тараалт**






Өнгөрсөн хугацаанд хөрөнгийн зах зээл дээр бүртгэлтэй хувьцаат компаниудын хуваарилаж буй ногдол ашгийн хэмжээ жил бүр өсөн нэмэгдэж байна. Хэдийгээр ногдол ашиг өгч буй компаниудын тоо харилцан адилгүй байгаа ч тарааж буй ногдол ашгийн дүн ба нэгж хувьцаанд ногдох ногдол ашгийн хэмжээ нэмэгдсээр байна.

2010 оны эцсийн байдлаар нийт 336 ХК-ийн 2,734,535,613 ширхэг хувьцаа бүртгэлтэй байгаагаас төрийн өмчит хувьцаат компанийн 1,854,363,339 ширхэг хувьцаа бүртгэлтэй байгаа ба 13 төрлийн 616,567 ширхэг компанийн бонд, 4 төрлийн 333,000 ширхэг Засгийн газрын бонд тус тус бүртгэлтэй байна.

Өнгөрсөн онтой харьцуулахад хөрөнгийн зах зээл дээр бүртгэлтэй компанийн тоо 22 компаниар буурсан ба үүнд хязгаарлагдмал хариуцлагатай компани болж хэлбэрээ өөрчлөх үзэгдэл ихэнх хувийг нь эзэлж байна.



2010 онд “Авто тээвэр 28”, “Өгөөж сүмбэр”, “Хайлааст” “Цацрал мон”, “Илч архангай”, “НИК”, “СББ”, “Хаш орд”, “Ардын эрх” зэрэг 9 ХК-ийн гаргасан үнэт цаасыг бүртгэлээс хассан бөгөөд “Шарын гол” ХК-ийн хяналтын багцын хувьцааг эзэмшигчдээс ирүүлсэн бусад хувьцаа эзэмшигчдийн өмчлөлийн хувьцааг худалдаж авахаар гаргасан саналыг зохих хууль, журмын дагуу хянаж Хорооны хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэсэн.

“Монгол базальт”, “Туул сонгино усны нөөц”, «Монад», «НИК», «Анод», «Монфрэш шүүс» ХКиудын гаргасан тодорхой хэмжээний энгийн хувьцаа, «Их барилга төсөл 360», «Анод бонд», «Бүтээн байгуулалт», “Нийслэл өргөө” гэсэн өрийн бичгүүдийг үнэт цаасны дэлгэрэнгүй бүртгэлээс хассан.

2010 онд бүртгэлээс хасагдсан 13 ХК-ийн нийт 5,528,023,627.07 төгрөгийн ногдол хувийн мөнгөн хөрөнгийг төлбөр тооцооны төв байгууллагад шилжүүлсэн байна.

“Монголиа девелопмент ресорсес”, “Хай би ойл”, “Нако түлш”, “Шарын гол” ХК-иудын нэмж үнэт цаас гаргахаар ирүүлсэн хүсэлтийг холбогдох хууль журмын дагуу хянан шийдвэрлэсэн бөгөөд Хорооны хуралдаанаар “Хай би ойл”, “Нако түлш” ХК-иудын нэмж үнэт цаас гаргах асуудлыг зөвшөөрсөн.

## **2.2. Үнэт цаасны зах зээлийн талаарх эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох ажлын талаар**

Хороо 2010 онд хөрөнгийн зах зээлийн талаарх эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох талаар дараахь ажлуудыг хийж гүйцэтгэсэн.

Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулсан бөгөөд энэ хуультай холбоотой холбогдох хуулиудад нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг мөн боловсруулсан. Тухайлбал, Эрүүгийн хууль, Төрийн хяналт, шалгалтын тухай хууль, Даатгалын тухай хууль, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай зэрэг хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг тус тус боловсруулсан.

Хуурамч мэдээлэл өгөх замаар нийтэд үнэт цаас гаргах, зах зээлийг урвуулан ашиглах, дотоод мэдээлэл ашиглан арилжаанд оролцох гэмт хэргийн бүрэлдэхүүнийг нарийвчлан тодорхойлох чиглэлээр Эрүүгийн хуульд, үнэт цаасаар гэрчлэгдсэн эрхийг сэргээх талаарх Санхүүгийн зохицуулах хорооны болон шүүх / арбитр/-ийн бүрэн эрхийг зааглаж, үнэт цаасыг шударгаар олж авсан хөрөнгө оруулагчийн эрхийг хангах чиглэлээр Иргэний хуульд, нийгмийн болон тэтгэврийн даатгалын сангийн хөрөнгийн тодорхой хэсэг, даатгалын компаниуд хөрөнгийн зах зээлд оролцох эрх зүйн орчныг бүрдүүлж, мэргэжлийн хөрөнгө оруулагчдыг бий болгох чиглэлээр Нийгмийн даатгалын тухай, Даатгалын тухай хуульд зохих өөрчлөлт оруулах саналуудыг гаргаад байна.

Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл батлагдсанаар Монгол Улсын хөрөнгийн зах зээлийн дэд бүтэц олон улсын нийтлэг жишигт хүрэх, эрсдлээс сэргийлэх, тогтвортой хөгжих орчин бүрдэж, санхүүгийн зах зээл дэх хөрөнгийн зах зээлийн гүйцэтгэх үүрэг, үр нөлөө нэмэгдснээр бусад орнуудтай адил Монгол Улсын эдийн засгийн хөгжилд хөрөнгийн зах зээлийн эзлэх байр суурь нэмэгдэх юм.

Ингэснээр Монгол Улсын санхүүгийн зах зээлийн банкны бус секторыг хөгжүүлж, банкны зээлийн санхүүжилтээс хэт хараат байгаа өнөөдрийн байдлаас ангижирч, санхүүжилт, хөрөнгө оруулалтыг бий болгох шинэ хувилбаруудыг нэмэгдүүлж, гадаад, дотоодын хөрөнгө оруулагч тус зах зээлээс өгөөж хүртэх боломж улам бүр нэмэгдэнэ гэж үзэж байна.

Олон улсын компанийн засаглалын үндсэн зарчмууд болох ТУЗ-ийн үйл ажиллагааны тасралтгүй байдал, тэдгээрийн дэргэдэх хороодын үйл ажиллагаа, нээлттэй тайлагналын тогтолцоо, хараат бус удирдлагын асуудал болон жижиг хувьцаа эзэмшигчдийн эрхийг хамгаалах чиглэлээр тодорхой өөрчлөлтүүдийг тусгасан Компанийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын тухай нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулсан

Хөрөнгө оруулалтын сангийн хуулийн төслийг боловсруулсан.

Хорооны зүгээс хамтын хөрөнгө оруулалтын эрх зүйн орчин бүрдээгүйгээс иргэд хөрөнгийн зах зээлд оролцох оролцоо хязгаарлагдмал, Монголын эдийн засагт хөрөнгө оруулах сонирхолтой гадаадын хөрөнгө оруулагчдад эрх зүйн орчин дутагдаж, хөрөнгө оруулалтыг хумихад хүргэж байна гэж үзэж байгаа юм.

Өмнө нь өмч хувьчлалын эхэн үед иргэд ХОЭБ-ээр хувьцаа аваад үлдсэн бутархай үлдэгдлийг нийлүүлэн, тухайн үед Хөрөнгийн биржийн салбар хэлбэрээр ажиллаж байсан брокерийн пүүсийн дэргэд хамтын сан байгуулсан туршлага манай улсад байдаг бөгөөд брокерийн пүүсүүд компанийн хэлбэртэй болж зохион байгуулагдах үед 10 гаруй хамтын сан нь хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагаа эрхлэх компани болж өөрчлөн байгуулагдсан, үлдсэн хэсэг нь санг бүрдүүлсэн хөрөнгөө гишүүддээ тараагаад татан буугдсан байдаг.

Хувьцаа хэлбэрээр байршсан хөрөнгөө худалдан борлуулж чадаагүйгээс гишүүддээ тарааж чадаагүй хөрөнгийн зарим хэсэг нь өнөөг хүртэл Үнэт цаасны төлбөр тооцоо, төвлөрсөн хадгаламжийн төвд хадгалагдсаар байна.

Үйл ажиллагааны эрх зүйн орчин дутмаг, мэргэжлийн удирдлага хараахан бэлтгэгдээгүй, мөн тухайн үед хөрөнгийн зах зээл дээр үнэт цаасны эрэлт нийлүүлэлт бараг зогсоод байсан, зах зээлийн хөгжлийн түвшин доогуур байсан зэргээс хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагаа эрхлэхээр компани болж өөрчлөн байгуулагдсан хэсэг нь шаардлагын түвшинд төлөвшиж чадалгүй татан буугдсан гэж үзэж болох юм.

Иймд хөрөнгийн зах зээлийн хөгжлийн түвшин шинэ шатанд гарч, гадаадын хөрөнгө оруулагчдын Монголын эдийн засагт хөрөнгө оруулах сонирхол нэмэгдсээр байгаа, уул уурхайн томоохон төслүүдийг хэрэгжүүлэхэд хөрөнгө оруулах нь Монголын эдийн засагт ч, гадаадын хөрөнгө оруулагчдад ч ашигтай байх боломжийг нээгдүүлж байгаа зэрэг нь хамтын хөрөнгө оруулалтын эрх зүйн орчинг яаралтай бүрдүүлэхийг шаардаж байгаа юм.

Энэ нь гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдыг татан оруулах замаар хөрөнгө оруулагчдын хүрээг өргөжүүлэн үнэт цаасны зах зээл дэх эрэлтийг нэмэгдүүлэх, зах зээлийн дэд бүтцийг хөгжүүлэхэд ч тус нэмэр болох юм.

Хамтын хөрөнгө оруулалтын байгууллага нь том жижиг олон хөрөнгө оруулагчдын хөрөнгийг нэгтгэж, мэргэжлийн түвшинд удирдан хөрөнгийн зах зээл дээр үйл ажиллагаа явуулснаар анхдагч зах зээлийг идэвхижүүлэх, хоёрдогч зах зээлийн хөрвөх чадварыг дээшлүүлэх, үнэт цаас гаргагч компанийн засаглалыг сайжруулах зэргээр зах зээлийн хөгжилд чухал нөлөө үзүүлэх болно.

Өмч хувчлалын үр дүнд манай орны иргэн бүр хувьцаа эзэмшигч болсон боловч хүн бүр зах зээлийн байдалд мэргэжлийн үүднээс дүн шинжилгээ хийж, хөрөнгө оруулалтын оновчтой шийдвэр гаргах боломжгүй байгаа өнөө үед хамтын хөрөнгө оруулалтын байгууллагын гүйцэтгэх үүрэг маш их байгаа юм.

Дээрх дурдсан хуулийн төслүүдээс гадна Төв банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, Банкны тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, Үнэлгээний тухай хуулийн төсөл, Зээлийн мэдээллийн сангийн тухай хуулийн төсөл зэрэг хуулийн төслүүдэд санал өгч хамтран ажиллалаа.

Хөрөнгийн зах зээлийг 2010-2012 онуудад хөгжүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Засгийн газрын түвшинд танилцуулан, Засгийн газрын 2010 оны 115 дугаар тогтоол батлагдсанаар төрийн болон төрийн бус байгууллагын хүрээг бүрэн хамарсан, цогц бөгөөд харилцан уялдаа бүхий арга хэмжээг хэрэгжүүлэх зорилгын үндэс суурийг тавьж чадлаа.

Аливаа хуулийн этгээдээс сайн дурын үндсэн дээр энгийн хувьцаа худалдан авах санал гаргах харилцааг зохицуулах “Хувьцаат компанийн хувьцааг заавал болон сайн дурын үндсэн дээр худалдан авах санал гаргах ажиллагааны журам”, “Нийтэд санал болгон гаргах үнэт цаасыг бүртгэх тухай” болон “Зохицуулалтын байгууллагаас авах хөлсний тухай журам”, “Харилцагчийн мөнгөн хөрөнгийг хамгаалах тухай журам”, “Үнэт цаас гаргагчаас үнийн мэдрэмжтэй мэдээллийг үнэт цаасны зах зээл, олон нийтэд хүргэх тухай журам”, “Санхүүгийн зохицуулах хорооноос олгосон зөвшөөрөл эрхийн нэгдсэн бүртгэл хөтлөх журам”-д тус тус нэмэлт, өөрчлөлт оруулах журмын төслийг боловсруулж, шийдвэр гарсан байна.

Санхүүгийн нэгдсэн зохицуулалт, хяналт шалгалтын үр дүнтэй байдлыг бүрдүүлэх, зохицуулалтын байгууллагуудын ажлын уялдаа холбоог сайжруулах зорилгоор Монголбанкт хамтран батлах “Санхүүгийн нэгдэлд хяналт шалгалт хийх журам”-ын төслийг боловсрууллаа.

### **2.3. Үнэт цаасны зах зээлийн талаарх хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, хяналт шалгалт хийх ажлын талаар**

Тайлант хугацаанд үнэт цаасны мэргэжлийн оролцогчид болон хувьцаат компаниудын үйл ажиллагаанд газар дээрх хяналт, шалгалт хийх нэгдсэн төлөвлөгөө гаргаж батлагдсан удирдамжийн дагуу уг ажлыг хийж гүйцэтгэв.

Тайлант хугацаанд Дорнод, Хөвсгөл, Орхон, Өвөрхангай, Өмнөговь, Баян-Өлгий, Төв аймгууд болон Улаанбаатар хотын 57 ХК-д, ногдол ашгийн тараалтын асуудлаар 14 ХК-д, мэргэжлийн оролцогч 49 ХХК-д тус тус үзлэг, шалгалт хийсэн байна.

Хяналт, шалгалтын ажлаас онцгойлон дурдвал тусгай зөвшөөрөл нь цуцлагдсан “Эрдэнэт инвест” ХХК-ийн ХОС-гийн хэлбэрээр явуулж байсан үйл ажиллагаанд шалгалт хийж ЦЕГ-ийн Эрүүгийн цагдаагийн газарт эрүүгийн хэрэг үүсгүүлэхээр холбогдох дүгнэлт, нотлох баримтыг

бүрдүүлэн шилжүүллээ.

“MICC”, “Нортенсек”, “Монет” ХХК-иудын зүгээс гадаадын үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагуудаар дамжуулан гадаадын зах зээлээс үнэт цаас худалдан авах, худалдах үйлчилгээг үзүүлж буй зуучлалын үйл ажиллагаанд газар дээрх шалгалтыг хийж илэрсэн нийтлэг зөрчил, дутагдалд дүгнэлт хийж, заавар, зөвлөмж өгсөн.

Дундговь, Өвөрхангай, Дорнод, Баян-Өлгий аймгуудад үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн байгууллагатай хамтран үзлэг, шалгалт хийж, орон нутгийн иргэдэд үнэт цаасны зах зээлийн талаар мэдлэг олгох зорилгоор сургалт, ярилцлагыг зохион байгуулж ажиллаа.

Энэ арга хэмжээний хүрээнд үнэт цаасны төвлөрсөн хадгаламжид байгаа хөрөнгийн үлдэгдлийг шалган баталгаажуулах, данс нээх, ногдол ашиг, ногдол хувийн болон хувьцаа борлуулсны мөнгөн хөрөнгийг эздэд олгох ажил зохион байгуулсан.

Хувьцаат компаниудын хүрээнд тус Хорооны шийдвэрээр арилжааг нь зогсоосон хувьцаат компаниудын асуудлыг судлан, зохих шийдвэрийг гаргаж ажилласан болно. Хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалах үүднээс тухайн компанийн удирдлагууд, том хувьцаа эзэмшигчдийн буруутай үйл ажиллагаанаас өмч хөрөнгө нь үрэгдсэн байж болзошгүй гэж үзэж 55 ХК-ийн асуудал дээр онцгой анхаарал тавьж ажилласан бөгөөд эдгээрээс 20 ХК-нд холбогдох асуудлыг харьяалах цагдаагийн байгууллагуудад нь шалгуулахаар шилжүүлсэн.

Хорооны шийдвэрээр 2008 онд арилжааг нь зогсоосон 166 ХК-уудад хууль тогтоожмийн дагуу зохих шаардлагыг өгч ажилласан. Компанийн хувь нийлүүлэгчдийн хурлыг хуралдуулах, арилжааг нь сэргээх, эсхүл компанийг татан буулгах эсэх асуудлыг зохих хүсэлтэд нь тулгуурлан хянан шийдвэрлэсэн болно. Арилжааг нь зогсоосон ХК-иудын талаарх шийдвэрлэлтийн байдлыг хүснэгтээр үзүүлбэл:

2010 оны 12 дугаар сарын байдлаар

Д/д	Арилжааг нь зогсоосон ХК-ийн тоо	ХНХ-аа хуралдуулсан ХК-ийн тоо	Зохион байгуулалтын хэлбэрээ өөрчилсөн	Арилжаа сэргээх хүсэлт гаргасан ХК	Татан буугдсан
1	166	53	22	9	3

Түүнчлэн хувьцаат компанийн өмч хөрөнгийн өмчлөх эрхийн бүртгэлд өөрчлөлт оруулах тухай бүрд буюу бусдад худалдах, барьцаалах, зээл авах зэрэг 27 удаагийн тохиолдолд гарч буй шийдвэр нь эрх бүхий этгээдээс зохих журмын дагуу гаргасан хуулийн хүчин төгөлдөр шийдвэр мөн эсэх талаар хяналт тавьж ажилласан байна.

#### **2.4. ХК-иудын хуулиар хүлээсэн үүргийн хэрэгжилтийг хангахад чиглэсэн зайны хяналтын талаар**

Тайлант оны эхэнд бүртгэлтэй байсан нийт 376 ХК-иас ээлжит хурлын тухай мэдэгдэл, хурлын материалыг Хороонд ирүүлээгүй 212 ХК-ийн нэрс, удирдлагынх нь бүрэн эрх дуусгавар болсон талаарх мэдээллийг “Өдрийн сонин”-ын 2010 оны 8 дугаар сарын 12-ны дугаарт хэвлүүлээ.

Үнэт цаасны зах зээлийн мэргэжлийн оролцогч байгууллагуудад зайны хяналт тавьсан талаар болон ХК-иудын 2009 оны жилийн тайлан, 2010 оны хагас жилийн санхүүгийн тайланг болон мэргэжлийн оролцогч байгууллагуудын 2009 оны жилийн тайлан, 2010 оны бүх улирлуудын санхүүгийн тайланг шалган хүлээн авч нэгтгэсэн.

“МХБ” ХК-ийн арилжааны мэдээллийн санг өдөр, сар, улирлын ТОП-20 индексийн үзүүлэлт, өдөр тутмын арилжааны бүх хэлцлүүдийн жагсаалт, үнэт цаасны арилжааны сар бүрийн дүн, сар тутмын идэвхитэй арилжаалагдсан 30 үнэт цаас, зах зээлийн үнэлгээ өндөр 30 үнэт цаасны

арилжааны мэдээ, ханшийн хэлбэлзэл ихтэй байсан 20 үнэт цаасны талаарх сар тутмын мэдээ, рокер, дилерийн компани бүрийн арилжааны дүн гэсэн үзүүлэлтээр бүрдүүлсэн нь судалгааны ихээхэн ач холбогдолтой арга хэмжээ болсон.

Үнэт цаасны зах зээлийн мэдээллийн нэгдсэн сангийн журмын дагуу мэдээлэл, хяналтын FinA программ дээр мэдээллийн сан бүрдүүлэх ажлыг гүйцэтгэж байгаа бөгөөд өнөөгийн байдлаар үнэт цаасны дэлгэрэнгүй бүртгэл, түүний өөрчлөлтүүд, мэргэжлийн оролцогч байгууллагуудын санхүүгийн тайлангийн нэгдсэн үзүүлэлтийн нэгтгэл, түүний статистик шинжилгээ, үнэт цаас гаргагчдын санхүүгийн тайлангийн нэгдсэн үзүүлэлтүүдийн нэгтгэл, түүний статистик шинжилгээ, ХК-иудын Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 10 дугаар зүйлд заасан нийтлэг үүргийн биелэлтийн байдал зэрэг мэдээллүүдийг санд оруулаад байна.

## **2.5. Хувьцаа эзэмшигч, хөрөнгө оруулагчийн хууль ёсны эрх ашгийг хамгаалах талаар**

1997 оноос эхлэн компанийн удирдлага, эрх бүхий албан тушаалтан болон томоохон хувьцаа эзэмшигч, брокер, дилерүүдийн зүгээс хувьцаа эзэмшигч, хөрөнгө оруулагчдын үнэт цаасаар гэрчлэгдсэн өмчлөх эрхийг зөрчих, түүнд хохирол учруулах, ногдол ашиг хүртэх эрхийг хязгаарлах, хувьцааг өмчлөгчийн зөвшөөрөлгүй худалдах, бусдад шилжүүлэх, компанийн хөрөнгийг үнэгүйдүүлэх, хуульд заасан журам зөрчиж бусдад худалдах, шилжүүлэх зэрэг хууль бус үйл ажиллагаа хийгдэж байсны үр дагавар арилгах ажил хийгдсээр байна.

Бүртгэлтэй ХК-ийн дийлэнх олонх нь хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаа хийдэггүй, хувьцаа эзэмшигчдийг мэдээллээр хангадаггүй, хяналтын багц эзэмшигчид нь хуулиар хүлээсэн үүргээ биелүүлэхгүй, компанийн хөрөнгийг дур мэдэн зарцуулах, ногдол ашиг хуваарилахгүй байх зэргээр жижиг хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хохироох явдал түгээмэл байна.

Тайлант онд Хороонд хандан өргөдөл гаргасан хөрөнгө оруулагч, иргэн, хуулийн этгээдүүд болон хяналт шалгалтын дүнгийн талаар нийт 82 улсын байцаагчийн албан шаардлагыг холбогдох хуулийн этгээд, албан тушаалтанд хүргүүлж, улсын байцаагчийн 7 удаагийн захиргааны актаар нийт 710,000 төгрөгийн торгууль ногдуусан байна.

Тайлангийн хугацаанд хувьцаа эзэмшигчдийн хувьцааг тэдний зөвшөөрөлгүй биржийн арилжаагаар худалдаж, завшсан үйлдүүдийн талаарх гомдол ихээр ирж нийт 322 өргөдлийг хүлээн авч Иргэний хууль, Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулиар олгогдсон бүрэн эрхийнхээ хүрээнд, шүүхийн бус журмаар урьдчилан шийдвэрлэж ирлээ.

“Эрдэнэт инвест” хөрөнгө оруулалтын сан, “Эрдэнэст” брокер, дилерийн компанийн удирдлагуудад холбогдох бусдын үнэт цаасаар гэрчлэгдсэн эрхийг зөрчиж, их хэмжээний хохирол учруулсан хэргийг урьдчилан шалгаж тогтоон, холбогдох нотлох баримтуудыг бүрдүүлэн харьяалах нутаг дэвсгэрийнх нь Цагдаагийн албанд шилжүүлж, өмнө шилжүүлээд байсан “Мөнхөд” ХХК-д холбогдох эрүүгийн хэрэгт албан ёсны шинжээчийн дүгнэлт гаргаж, шаарлагатай бүх арга хэмжээг авч ажиллав.

Түүнчлэн иргэдийн зах зээлийн харилцаанд оролцох боломжийг бий болгох үүднээс тусгай зөвшөөрөл нь хүчингүй болсон брокер, дилерийн компаниудын харилцагчдыг шилжүүлэх тухай журмын дагуу Хөвсгөл, Архангай, Завхан аймгийн хувьцаа эзэмшигчдэд үйлчлэх компанийг сонгон шалгаруулж, Архангай, Завхан аймагт “Гүүдсек” ХХК, Хөвсгөл болон Орхон-Уул аймагт “Би Ди Сек” ХК үйл ажиллагаа явуулах боллоо.

Хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах чиглэлээр үнэт цаасаар гэрчлэгдсэн өмчлөх эрхийг нь сэргээх, үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт оруулах зэрэг асуудлаар гаргасан Хорооны тогтоол буюу захиргааны актуудыг 2010 онд Захиргааны хэргийн шүүхэд 6 хэргийг, Иргэний хэргийн шүүхэд 3 хэргийг шалгасан бөгөөд дээрх хэргүүдийн 2010 онд болсон нийт 21 шүүх хуралдаанд оролцсон.

## **2.6. Үнэт цаасны зах зээлийг сурталчлах, хувьцаа эзэмшигч, хөрөнгө оруулагчийн санхүүгийн боловсролыг дээшлүүлэх талаар**

Хороо нь тайлант онд олон нийтийн мэдлэг, боловсролыг дээшлүүлэх зорилтын хүрээнд улсын хэмжээнд мөрдөж буй ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөрт үнэт цаасны зах зээлийн сургалтыг оруулах санал боловсруулан Боловсрол, соёл, шинжлэх ухааны яаманд хүргүүлээд байна.

Үүний зэрэгцээ эрх зүйн чиглэлээр зохион байгуулагдаж буй бакалавр, магистрын болон мэргэшил дээшлүүлэх хуульчдын сургалтад санхүүгийн зах зээлийн талаарх нарийвчилсан хөтөлбөртэй хичээл оруулах чиглэлээр Хууль зүй, дотоод хэргийн яам болон Хууль зүйн үндэсний төвтэй хамтран ажиллаж байна.

Хөрөнгийн зах зээлийн үйл ажиллагаанд гарч байгаа хэрэг, маргааныг шийдвэрлэхэд тулгамдаж буй асуудлууд сэдэвт семинарыг ХЗДХЯ-тай хамтран хууль сахиулагчдын дунд АХБ-ны санхүүжилтэйгээр зохион байгуулж, бэлтгэл ажлыг ханган ажиллав.

Хороо нь Прайм Инфо төвтэй хамтран 2010 оны 10 сард “Mongolia: Money and Market” Санхүүгийн чуулга уулзалтыг Улаанбаатар хотноо анх удаа амжилттай зохион байгууллаа. Энэхүү арга хэмжээнд Монголбанк, Сангийн яам, Үндэсний хөгжил, шинэтгэлийн хороо албан ёсны дэмжигч төрийн байгууллагаар оролцсон бөгөөд нийт 450 гаруй төлөөлөгчид оролцсон байна.

Уг чуулганы хүрээнд “Үнэт цаас хөрөнгийн зах зээлийн талаархи төрийн зохицуулалт, эрх зүйн орчин”, “Үнэт цаасны зах зээлийн мэргэжлийн оролцогчдод тулгарч буй тулгамдсан асуудлууд”, “Монголын ипотекийн зах зээлийн тулгамдсан асуудлууд, хөгжлийн боломж”, “Монголын үл хөдлөх хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны зах зээлийн хөгжилд нөлөөлж буй асуудлууд хүчин зүйлс”, “Үл хөдлөх хөрөнгийн төсөлд бондоор санхүүжилт хийсэн жишээ: ололттой ба дутагдалтай талууд”, “Монгол Улс дахь үнэт цаасны чанарын асуудал, үнэт цаасны шинжилгээ судалгааны чадавхийг хөгжүүлэх нь”, “Монголд институционал хөрөнгө оруулагчдыг бий болгож хөгжүүлэх нь”, “Засгийн газрын болон орон нутгийн бондын зах зээлийн хөгжил, боломж”, “Монголын Хөрөнгийн Биржийн хувьчлал, хөгжлийн асуудал”, “Компаний сайн засаглалыг Монголд төлөвшүүлэх нь”, “Бид бизнесийг үнэлж чадаж байна уу”, “Монголд “Зэрэглэл тогтоолт” /Rating/-ийг хөгжүүлэх шаардлага, эрэлт хэрэгцээ”, “Санхүүгийн бүртгэл, тайлагнал болон аудитын тулгамдсан асуудлууд” зэрэг сэдвүүдээр илтгэл тавигдаж, хэлэлцүүлэг явагдсан нь санхүүгийн салбарынхны сонирхлыг татсан, үр дүнтэй ажил болсон.

Хороо нь “Монгол Улсын хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэх нь” сэдэвт эрдэм шинжилгээ, судалгааны шилдэг бүтээл шалгаруулах уралдааныг мэргэжлийн байгууллага, их дээд сургуулийн хууль эрх зүй, санхүү эдийн засгийн чиглэлийн тэнхим, профессорын баг, эрдэмтэн, судлаач, оюутнууд болон сонирхогчдын дунд зарлаж, дүгнэлээ.

АХБ-тай хамтран Үнэт цаасны зах зээлийн тухай хууль тогтоомжийн эмхэтгэл, хөрөнгийн зах зээлийн тухай гарын авлага, ханын зурагт хуудас зэргийг хэвлүүлж албан хэрэгцээнд гаргасан.

2010 онд АХБ-тай хамтран нийтийг хамарсан “Иргэдийн санхүүгийн боловсролд” өдөрлөгийг Баян-өлгий, Дорнод, Өвөрхангай, Завхан, Хөвсгөл аймгийн төвүүдэд болон Улаанбаатар хотын Баянгол, Сүхбаатар дүүргүүдэд тусгай хөтөлбөрөөр зохион байгууллаа. нийт 956 хүнд зах зээлийн талаар мэдээлэл хүргэж, богино хугацааны сургалтыг зохион байгуулж, иргэдийн сонирхсон асуудлуудаар зөвлөгөө өгч, танилцуулга, лавлагаа, зөвлөмжийн эмхэтгэлийг тараан сурталчилсан болно. Дээрх арга хэмжээний талаар тухайн орон нутгийн телевиз, радиоогоор нэвтрүүлэг бэлтгэгдэж гарсан болно.

Газрын удирдлагуудаас “Би ТВ”, “UBS”, “Монгол телевиз”, “Си 1” телевизүүдээр цацагдсан нэвтрүүлгүүдэд оролцож СЗХ-ны хийж гүйцэтгэж буй ажил болон зах зээлийн нөхцөл байдлын талаар ярилцлага, “ТВ 25” телевизээр шууд ярилцлагад оролцож, хөрөнгийн зах зээлийн цаг үеийн тулгамдсан асуудлын талаар мэдээлэл хийж, үзэгчдийн сонирхсон асуултад хариулсны дээр “Зууны шуудан” сонин, “Хөрөнгийн зах зээл” сэтгүүлд 5 удаа ярилцлага өгч сурталчлав.

Үнэт цаасны зах зээл дээр ажиллагсдад зориулсан семинар, үүлзалт-ярилцлагыг мэргэжлийн оролцогчийн ёс зүйн асуудал, нийтэд санал болгон үнэт цаас гаргагчдад тавих шаардлага, компанийн засаглалын зарчим, хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн төслийн хэлэлцүүлэг зэргээр зохион байгууллаа.

КТМС-ийн ахлах курсын оюутнуудын дунд 2010 оны 11 дүгээр сард зохион байгуулагдсан “Үнэт цаасны зах зээл” сэдэвт уралдаанд онол арга зүйн болон сургалтын материал, гарын авлага, материалын туслалцаа үзүүлж хамтран ажилласан.

Санхүү, эдийн засгийн дээд сургуулийн магиструудын дунд компанийн засаглалын асуудлаар, Шихихутаг дээд сургуулийн төгсөх ангийн оюутнуудын дунд үнэт цаасны зах зээлийн эрх зүйн зохицуулалтын талаар тус тус лекц уншиж хамтран ажиллалаа.

Улсын бүртгэлийн газрын хяналтын байцаагчдын улсын зөвлөгөөн дээр Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн байцаагчид, Авилгатай тэмцэх газрын мөрдөн байцаагчдын дунд үнэт цаасны зах зээлийн харилцааны талаар ярилцлага зохион байгуулсан байна.

2010 оны 11 дүгээр сард Төрийн өмчийн хороо, Компанийн засаглалын хөгжлийн төвтэй хамтран төрийн өмчит хувьцаат компаниудын ТҮЗ-ийн дарга, гүйцэтгэх захирлуудын дунд компанийн сайн засаглалын асуудлаар сургалтыг амжилттай байгууллаа.

Монгол улсад мэдлэгт суурилсан эдийн засгийн төлөвшүүлэх нь сэдвээр МУШУТИС-иас зохион байгуулсан олон улсын бага хуралд “Санхүүгийн зах зээлд мэдлэгт суурилсан чиг хандлагыг нэвтрүүлэх нь” сэдэвт илтгэл тавьж хэлэлцүүлээ.

2010 оны 5 дугаар сарын 6-ны өдөр “Улаанбаатар” ЗБ-ын хурлын танхимд “Монгол улс дахь санхүүгийн салбарын үнэлгээ ба хөрөнгийн зах зээлийн шинэчлэл” олон улсын семинарыг зохион байгууллаа.

Тайлант онд үнэт цаасны зах зээл дээр ажиллахад эрх олгох сургалтыг зохион байгуулж 46 хүнд эрхийн үнэмлэхийг олгосон байна

Компанийн засаглалын зарчмыг түгээн сурталчлах, компанийн сайн засаглалыг дэмжих ажлын хүрээнд Санхүүгийн зохицуулах хороо тайлант жилд хариуцсан салбарын засаглалыг сайжруулах ажлын хүрээнд эрх зүйн таатай орчин бүрдүүлэх, харилцагчдын эрх ашгийг хамгаалах салбар бүрийн компанийн засаглалын кодексыг улам сайжруулах, шинээр бий болгох зорилт тавин ажиллаж дараахь ажлыг хийж гүйцэтгэсэн.

1. “Компанийн засаглал” товхимолыг хэвлүүлж, Компанийн засаглалын форум зохион байгуулав.
2. Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүд, захирлуудад зориулсан гарын авлага боловсруулж, тэдний Компанийн засаглалын зарчимууд болон олон улсын шилдэг практикуудын талаарх мэдлэгийг дээшлүүлэх, сургахад чиглэсэн 15 модулаас бүрдсэн сургагч, багш нарыг бэлтгэх сургалтын хөтөлбөрийг Компанийн засаглалын хөгжлийн төвөөс зохион байгуулж эхлээд байна.
3. Хорооны вэб сайт дээр Компанийн засаглал болон салбарын бүхий л асуудлыг хөндсөн портал сайт байрлуулахаар бэлтгэл ажлыг хангалаа.
4. Хөрөнгө оруулалтын сангийн эрх зүйн орчинг бүрдүүлэх талаар Улсын Их Хурлын гишүүдийн оролцоотой “Компанийн засаглалын үндэсний хөтөлбөрийг боловсруулах” асуудлаар төрийн болон хувийн хэвшлийн байгууллагуудын удирлага, үнэт цаас гаргагч, ХХК-иудын болон бусад байгууллагын удирдлагыг хамруулсан хэлэлцүүлгийг санаачлан зохион байгуулж, “Компанийн засаглалын үндэсний хөтөлбөр”-ийг боловсруулж Засгийн газраар батлууллаа.

## ГУРАВ. БИЧИЛ САНХҮҮГИЙН САЛБАРЫН ТАЛААР

### 3.1. Банк бус санхүүгийн байгууллагын өнөөгийн байдал


Банк бус санхүүгийн байгууллагын /цаашид ББСБ гэх/ үйл ажиллагааны тогтвортой байдлын үндэс суурийг бэхжүүлэх чиглэлээр зохицуулалтын эрх зүйн орчинг боловсронгуй болгох, олон улсын нийтлэг жишигт нийцүүлэх зорилгоор эрх зүйн баримт бичгүүдийг олон улсын жишиг, стандартад нийцүүлэн шинээр болон шинэчлэн боловсруулах замаар дэд бүтэц, эрсдэлд тулгуурласан хяналт, зохицуулалтыг боловсронгуй болгож, тус салбарын хөгжил, цаашдын тогтвортой байдлын үндэс суурийг бэхжүүлэх алхмуудыг хийсэн болно.

Банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй нийт 182 ББСБ-ын 156 ББСБ нь Улаанбаатар хотод, 26 ББСБ нь орон нутагт үйл ажиллагаа явуулж байна. Мөн 15 ББСБ нь Япон, БНСУ, Итали зэрэг орнуудын 100 хувийн болон хамтарсан хөрөнгө оруулалттай байна.


Тайлант онд ББСБ-дын салбар, нэгжийн тоо 63, хувь нийлүүлэгчдийн тоо 582, ажиллагсдын тоо 880 гаруйд хүрсэн ба давхардсан тоогоор 158.5 мянга гаруй харилцагчдад санхүүгийн үйлчилгээ үзүүлжээ.

#### 1. Нийт актив

Нийт хөрөнгийн бүтэц



Эргэлтийн хөрөнгийн бүтэц /хувиар/





ББСБ-ын нийт актив 128.6 тэрбум төгрөгт хүрсэн нь банкны салбарын нийт активын 2.1 хувьтай тэнцэж байна.


Тайлант хугацаанд нийт актив өмнөх оны мөн үеэс 33.3 хувиар өссөн ба ийнхүү өсөхөд ББСБ-уудын үйл ажиллагааны үр дүн болох хуримтлагдсан ашгийн 54.1, нийт өр төлбөрийн 69.3 хувийн болон хувьцаат капитал /дүрмийн сан/-ын 20.6 хувийн өсөлтүүд тус тус голлох нөлөөг үзүүлсэн байна.

Зээлийн өрийн үлдэгдэл нь нийт активын 60.7 хувь, мөнгөн хөрөнгө 29.7 хувийг буюу нийт 90.4 хувийг эзэлж байгаа нь ББСБ-уудын үндсэн эрхэлж буй үйл ажиллагаа нь зээлийн үйл ажиллагаа байгаа болохыг илтгэж байна.

## 2. Зээлийн багцын чанар

ББСБ-уудын системийн нийт зээлийн багцын бүтцийг өмнөх онуудтай харьцуулбал дараах байдалтай байна. Өнгөрсөн 10 жилийн хугацааны туршид зээлийн багцад эзлэх чанаргүй зээлийн хувь хэмжээ 2007 онд хамгийн өндөр үзүүлэлттэй байсан ба 2009 онд өмнөх оноос 3.2 хувиар өссөн нь санхүү, эдийн засгийн хямралтай холбоотойгоор зээлдэгчдийн үйл ажиллагааны орлого буурсан, барьцааны эд зүйлийг худалдан борлуулах замаар зээлийг эргэн төлүүлэх хууль эрх зүйн орчин төдийлэн таатай бус байсан, зарим ББСБ-уудын удирдлагын хувьд зохих менежментийг хангаж ажиллаж чадахгүй байгаатай холбоотой байв.


2010 онд чанаргүй зээлийн хувь хэмжээ өмнөх оноос 2.9 хувиар буурсан үзүүлэлттэй байна.



Харин 2010 оны жилийн тайлант хугацааны зээлийн үзүүлэлтийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад, нийт зээлийн багц 40.7 хувиар өссөнөөс зээлийн багцад эзлэх хувийн жингээр хэвийн зээл 5.1 хувиар өссөн бол чанаргүй зээл 2.8 хувиар буурсан үзүүлэлттэй байна.


Чанаргүй зээлийн нийт зээлийн багцад эзлэх хувь 6.1 хувь байгаа нь ББСБ-уудын зээлийн багцын чанар системийн хэмжээгээр сайн, харин 3.7 тэрбум төгрөгийн зээлийн эрсдэлийн сан байгуулсан нь чанаргүй зээлийн 78.7 орчим хувьтай тэнцэж байгаа үзүүлэлттэй байна.

### Нийт зээл, зээлийн чанар /тэрбум төгрөгөөр/



### 3. Зээлийн хүүгийн түвшин

#### БАНК, ББСБ-ЫН ЗЭЭЛИЙН ХҮҮГИЙН ТҮВШИННИЙ СУДАЛГАА




ББСБ Банк Банк, ББСБ-ын хооронд зээлийн өрсөлдөөн эрчимтэй өрнөж, зээлийн хүүгийн түвшин 2006 оноос тогтвортой буурч эхэлсэн ч дэлхийг хамарсан санхүү, эдийн засгийн хямралаас үүдэлтэй дотоодын инфляцийн түвшин өссөнтэй уялдуулан 2008-2009 онуудад зээлийн хүүгийн түвшин өссөн. Гэвч 2010 оноос санхүү, эдийн засгийн байдал тогтворжих нааштай хандлага илэрч буйтай холбоотойгоор зээлийн хүүгийн түвшин буурах төлөв ажиглагдаж байна.

### 4. Нийт эх үүсвэр

ББСБ-ын нийт эх үүсвэрийн гол зарим үзүүлэлтүүдийг өмнөх онуудтай харьцуулж графикаар харуулбал дараах байдалтай байна.

#### Нийт эх үүсвэрийн бүтэц




Тайлант хугацаанд өмнөх оны мөн үетэй харьцуулахад нийт өр төлбөр 69.3 хувиар, эзэмшигчдийн өмч 22.9 хувиар тус тус өссөн бөгөөд 2009 оны тайлант хугацаанд нийт эх үүсвэрийн 24.4 хувийг нийт өр төлбөр, 77.6 хувийг эзэмшигчдийн өмч эзэлж байсан бол 2010 оны тайлант хугацааны нийт эх үүсвэрт эзлэх нийт өр төлбөр 28.5 хувь, эзэмшигчдийн өмч 71.5 хувь болж өөрчлөгдсөн байна.

Харин өөрийн хөрөнгө буюу эзэмшигчдийн өмчийн өсөлтөд Хорооны 2008 оны “Банк бус санхүүгийн байгууллагын дүрмийн сангийн доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 169 дүгээр тогтоолоор үүрэг болгосны дагуу ББСБ-ууд дүрмийн сангаа нэмэгдүүлсэн нь голлох үүрэг гүйцэтгэжээ.

Бусдаас татан төвлөрүүлсэн хөрөнгийн эх үүсвэр өмнөх оноос өссөн, өөрийн хөрөнгийн эх үүсвэр нэмэгдсэн нь ББСБ-уудын өөрийн хөрөнгөөр эрсдэл даах чадварыг нэмэгдүүлж, улмаар санхүүгийн тогтвортой байдлын хувьд эерэг үзүүлэлт болж байна.

### Эзэмшигчдийн өмчийн бүтэц /хувиар/




ББСБ-ын нийт өөрийн хөрөнгө 92.0 тэрбум төгрөгт хүрсэн нь банкны салбарын эзэмшигчдийн өмчийн 24.0 хувьтай тэнцэж байна.

ББСБ-ын дүрмийн сангийн өсөлттэй холбоотойгоор өөрийн хөрөнгийн 87.0 хувь нь ББСБ-ын дүрмийн сангаас бүрдэж байна.

## 5. Нийт өр төлбөр

ББСБ-ын нийт өр төлбөрийг өмнөх онуудтай харьцуулж графикаар харуулбал дараах байдалтай байна. Тайлант хугацаанд ББСБ-ын нийт өр төлбөр өмнөх оны мөн үеэс 69.3 хувиар өсч, нийт эх үүсвэрийн 28.5 хувьд хүрчээ. Нийт эх үүсвэрт эзлэх нийт өр төлбөр өссөн гол шалтгаан нь нэг талаас ББСБ-уудын хувьцаат капитал болон хуримтлагдсан ашиг өссөн, нөгөөтэйгүүр, ББСБуудын итгэлцлийн үйлчилгээний өглөг, дотоод, гадаадын банк, санхүүгийн байгууллагаас авсан зээлийн хэмжээ өссөнтэй холбоотой.

## Нийт өр төлбөрийн бүтэц /хувиар/



## 6. Ашигт ажиллагаа

Тайлант хугацааны нийт орлого өмнөх оноос 12.8 хувиар өссөн нь БСББ-уудын эзэмшигчдийн өмчийн өсөлт, бусдаас татсан эх үүсвэрийн өсөлттэй шууд холбоотой бөгөөд нийт орлогын өсөлтөд үндсэн үйл ажиллагааны орлого болох хүүгийн болон хүүгийн бус орлогын өсөлт нөлөөлсөн байна. Харин хүүгийн бус орлого өмнөх оны мөн үеэс 24.4 хувиар буурсан байх ба тайлант хугацааны нийт орлогын 68.7 хувийг хүүгийн орлого, 28.0 хувийг хүүгийн бус орлого эзэлж байна.


Тайлант хугацааны нийт зардал өмнөх оны мөн үеэс 5.9 хувь өссөн. Харин нийт зардлын бүтцэд дараах өөрчлөлтүүд оржээ. Тухайлбал, хүүгийн зардал 2.6 хувиар буурсан, хүүгийн бус зардал 2.9 хувиар, болзошгүй эрсдэлийн зардал 24.9 хувиар, үндсэн бус үйл ажиллагааны зардал 34.4 хувиар, орлогын татварын зардал 50.9 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй байна.

Өөрөөр хэлбэл, 2010 оны тайлант хугацаанд нийт орлого 12.8 хувиар өссөн бол нийт зардал 5.9 хувиар өссөн байна. БСББ-ын үйл ажиллагаа идэвхижиж, цар хүрээ өргөжсөнтэй уялдан хүүгийн орлого нь тогтвортойгоор нэмэгдсэн ч, зардлын түвшингийн өсөлт харьцангуй өндөр байна.

Активын болзошгүй эрсдэлийн зардлын өсөлт нь БСББ-уудын зээлийн багцын чанар муудаж, чанаргүй зээлийн хэмжээ байнга өсөн нэмэгдсээр байгааг илтгэж байна.


БСББ-ын орлого, зарлага, ашгийн үзүүлэлтийг өмнөх онуудтай харьцуулбал дараах байдалтай байна.

БСББ-ЫН ОРЛОГО, ЗАРЛАГА, АШИГ /тэрбум төгрөгөөр/



Харин сүүлийн 11 жилийн хугацаанд ББСБ-ын татварын дараах цэвэр ашгийн нийт орлогод эзлэх хувь хэмжээ дараах байдалтай байна.

Тайлант хугацаанд нийт 7.1 тэрбум төгрөгийн татварын дараах цэвэр ашигтай ажилласан нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 43.0 хувийн өсөлттэй ба энэ үзүүлэлтийг тухайн тайлант үеүдийн нийт орлогод эзлэх хувиар тооцвол 5.0 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Өөрөөр хэлбэл, өмнөх онтой харьцуулахад нийт ашиг нэмэгдсэн нь ББСБ-ын активын өсөлт, ББСБ-ын тооны өсөлтөөс гадна тэдгээрийн үйл ажиллагааны үр ашиг нэмэгдсэнтэй шууд хамааралтай болохыг харуулж байна.



ББСБ-ын ашигт ажиллагааны түвшинг илэрхийлсэн активын өгөөж (ROA) системийн дунджаар 7.2 хувь, өөрийн хөрөнгийн өгөөж /ROE/ 8.8 хувь ба татварын дараах ашиг 7.1 тэрбум төгрөгт хүрсэн байна.

### 3.2. Банк бус санхүүгийн байгууллагын талаарх эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох ажлын талаар

Банк бус санхүүгийн байгууллагын салбарын үйл ажиллагаанд нэн тааламжтай орчинг бий болгох, санхүүгийн зах зээлд шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээг нэвтрүүлэх замаар санхүүгийн зуучлалыг гүнзгийрүүлэн хөгжүүлж, эрх зүйн боломж, бололцоог бүрдүүлэх, санхүүгийн салбарын хөгжлийн чиг хандлагыг олон улсын жишигт нийцүүлэх, зохицуулалтын уян хатан бодлого баримтлах зорилгоор Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг Хорооноос боловсруулан УИХ-ын гишүүдэд хүргүүлээд байна. Хуулийн төсөл батлагдсанаар банк бус санхүүгийн байгууллагын салбарын зохицуулалтын эрх зүйн орчин тодорхой болж, тэдгээрийн үйл ажиллагааны цар хүрээ өргөжих, санхүүгийн зуучлалын шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээ, үйл ажиллагааг санхүүгийн зах зээлд нэвтрүүлэхийг Хороо зохицуулалтын бодлогоор дэмжих, түүнд тавигдах шаардлага, хориглох зүйл болон хяналтын оновчтой тогтолцоог бүрдүүлэх, хууль тогтоомж зөрчигчдөд авах албадлагын арга хэмжээ, ногдуулах захиргааны шийтгэлийн хэмжээг бодитой тогтоосноор тухайн салбарт учирч болзошгүй эрсдэлийг бууруулж, цаашдын тогтвортой хөгжилд ач холбогдолтой арга хэмжээ болох юм.

Үүний дүнд санхүүгийн зах зээлийн банк бус санхүүгийн салбарыг хөгжүүлэх эрх зүйн орчин боловсронгуй болж, үйл ажиллагаа эрхлэх таатай орчинг бүрдүүлсэнээр хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, салбарын хөгжлийн эрчимжилтийг бататгах, төрөөс баримталж буй мөнгөний бодлогыг зөв зүйтэй, үр дүнтэй хэрэгжүүлэхэд тодорхой хэмжээний нөлөө үзүүлж, улмаар нийгэм, эдийн засагт банк бус санхүүгийн байгууллагын гүйцэтгэх үүргийг нэмэгдүүлнэ.

Даатгалын тухай хуулийн 27.1 дэх заалтыг өөрчлөх хуулийн төслийг боловсруулж, “Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд заалт болгон хавсМэргэжлийн

Хорооноос зээлийн батлан даалтын үйлчилгээг бодлогоор дэмжих, тодорхой хугацаанд төрийн зохицуулалтаар хангах зорилгоор “Зээлийн батлан даалтын үйлчилгээний зохицуулалтын түр журам”, “Банк бус санхүүгийн байгууллагаас хаалттай өрийн бичиг гаргах журам”-ыг баталсан байна.

Шинэчлэн найруулж буй Валютын тухай хуулийн төсөлд валютын биржийн эрх зүйн зохицуулалтын талаар холбогдох нэмэлт, өөрчлөлтийг оруулах тухай асуудлыг Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэхээр бэлтгээд байна.

Санхүүгийн салбарын зээлийн эрсдэлийг бууруулах, жижиг дунд үйлдвэр эрхлэгчдийг төрөөс дэмжих ажлын хүрээнд “Зээлийн батлан даалтын сангийн тухай” хуулийн төслийг боловсруулах ажлын хэсэгт ажиллаж, зээлийн батлан даалтын сангийн үйл ажиллагаа эрх зүйн хувьд Банк бус санхүүгийн байгууллага байхаар хуулийн төсөлд тусгаад байна.

### **3.3. Банк бус санхүүгийн үйл ажиллагааны талаарх хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, хяналт шалгалт хийх ажлын талаар**

Санхүүгийн салбарын тогтвортой байдлыг хангах үндсэн зорилгын хүрээнд санхүүгийн тогтвортой байдал, бичил санхүүгийн зүүчлэл, цар хүрээ, хүртээмж, өрсөлдөөнийг дэмжиж, хууль, журмын хэрэгжилтийг хангуулах чиглэлээр хяналт тавин ажиллаж, санхүүгийн салбарт бий болсон тогтвортой байдал, нааштай хандлагыг хадгалах, цаашид улам бэхжүүлэн хөгжүүлэх асуудалд онцгой анхаарал хандуулсан.

Энэхүү бодлогын хүрээнд эрх зүйн орчин болон төрийн зохицуулалтыг тодорхой болгох, санхүүгийн зах зээлд шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээг нэвтрүүлэх асуудлыг шийдвэрлэхийн зэрэгцээ тайлант хугацаанд 20 хуулийн этгээдэд банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг, нэр бүхий 7 ББСБ-д банк бус санхүүгийн үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл төрөл нэмж олгох, 17 ББСБ-ын банк бус санхүүгийн зарим үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон байна.

Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хууль болон Аудитын тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах зорилгоор ББСБ, ХЗХ-ны 2009 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан болон аудитын дүгнэлтийг сонинд хэвлүүлж олон нийтэд хүргэж буйд хяналт тавьж ажилласан.

Тайлант онд ББСБ-ын санхүүгийн тайлан, тэнцлийг улирал бүр хүлээн авч, зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг хангаж ажилласан байдалд дүн, шинжилгээ хийн, илэрсэн зөрчлийг арилгуулах болон авч хэрэгжүүлбэл зохих арга хэмжээний талаар холбогдох үүрэг даалгавар, зөвлөгөөг давхардсан тоогоор нийт 285 тайлангийн хариугаар өгч ажиллалаа.

Газар дээрх хяналт шалгалтыг төлөвлөн ажиллаж ББСБ, ХЗХ-дын санхүү, төлбөрийн тогтвортой байдлыг хангах, үйл ажиллагаанд нь учирч болзошгүй эрсдэлээс сэргийлж тооцоолох, илэрсэн зөрчлийг арилгах зорилгоор Хорооны даргын удирдамжийн дагуу нийт 41 ББСБ, 63 ХЗХ-нд хийж гүйцэтгэн шалгалтын нэгдсэн дүнд үндэслэн холбогдох арга хэмжээг авч ажилласан.

Мөн 9 ББСБ-ын гадаад валютын арилжаа эрхлэх тусгай зөвшөөрлийн үйл ажиллагаанд газар дээрх үзлэгийг хийж гүйцэтгэлээ.

Газар дээрх шалгалтаар илэрсэн зөрчилд 4 ББСБ-д 4.910.0 мянган төгрөгийн захиргааны шийтгэвэр ногдуулж, илэрсэн зөрчлөө арилгуулах хугацаатай үүрэг даалгаврыг нийт 17 ББСБ-д Улсын байцаагчийн албан шаардлагаар тавьсан байна.

Зайны болон газар дээрх хяналт, шалгалтыг хэрэгжүүлэх явцад үйл ажиллагаандаа Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай болон бусад хууль, эрх бүхий байгууллагаас баталж гаргасан

журмыг мөрдөж ажиллаагүй 20 ББСБ-ын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг 3 сар хүртэл хугацаагаар түдгэлзүүлэн, үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг сэргээх тухай хүсэлтээ ирүүлсэн 5 ББСБ-д зөвшөөрөл олгосон байна.

Өөрийн хүсэлтээр татан буугдах шийдвэр гаргасан 15, тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлагыг биелүүлээгүй, сэргээх тухай хүсэлтээ ирүүлээгүй болон зарим нэр төрлийн банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэхгүй тухай шийдвэрээ гаргаж, хүсэлт ирүүлсэн 17 ББСБ-ын банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг тус тус хүчингүй болголоо.

Тайлант хугацаанд нэр бүхий 2 ББСБ-ын санхүүгийн үйл ажиллагаанд Монголбанкт хамтран нэгдсэн хяналт шалгалтыг явуулсан байна

Тогтвортой амьжиргаа-II төслийн Бичил санхүүгийн хөгжлийн сангийн бөөний зээлд хамрагдсан 2 ББСБ-ын санхүү, төлбөрийн чадварын үйл ажиллагаанд БСХС-ийн төлөөлөл болон Хорооны хянан шалгагч, улсын байцаагч хамтарсан шалгалтыг хийж гүйцэтгэсэн болно.


### 3.4. Хадгаламж зээлийн хоршоодын өнөөгийн байдал

Хорооноос хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан нийт 179 ХЗХ ны 74 нь Улаанбаатар хотод, 105 нь орон нутагт бүртгэлтэй байна. Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй ХЗХ-ны 65 нь Хасбанкны франчайзын үйлчилгээ гэрээ байгуулж ажиллаж байна. Тайлант онд хоршоодын нийт гишүүдийн тоо 26.0 мянгад хүрчээ.

#### 1. Татан төвлөрүүлсэн хадгаламж, олгосон зээл

ХЗХ-ны сүүлийн 5 жилийн гишүүдээс татан төвлөрүүлсэн хадгаламж болон олгосон зээлийн үзүүлэлт дараах байдалтай байна.


**ХЗХ-дын татсан хадгаламж, олгосон зээл**



ХЗХ-ны гишүүдээс татан төвлөрүүлсэн хадгаламжийн хэмжээ тайлант хугацаанд 34.8 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 16.3 хувиар, олгосон зээлийн өрийн үлдэгдэл 34.9 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 2.3 хувиар тус тус өсчээ.


#### 2. Төлбөр түргэн гүйцэтгэх чадвар

**Төлбөр түргэн гүйцэтгэх харьцаа**



Хорооны 2008 оны 180 дугаар тогтоолоор батлагдсан “Хадгаламж, зээлийн хоршооны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тооцож, хяналт тавих журам”-ын дагуу төлбөр түргэн гүйцэтгэх чадвар нь /түргэн борлогдох активаас богино хугацаат өр төлбөрийг хасч, гишүүдээс татан төвлөрүүлсэн хадгаламжид харьцуулж тооцно/ 5 хувиас дээш байхаар зохицуулсан ба төлбөр түргэн гүйцэтгэх чадварын зохистой харьцаа 22.9 хувь байгаа нь бүсдад төлөх төлбөрийг анхны шаардлагаар гүйцэтгэх чадамж сайжирсан байгааг харуулж байна.

### 3. ХЗХ-ны активын бүтэц



#### ХЗХ-ны нийт активын бүтэц

■ 77%	Зээл	■ 14%	Мөнгөнхөрөнгө
■ 1%	ӨБҮХХ	■ 3%	Үндсэн хөрөнгө
■ 5%	Авлага	□ 0%	Бусад эргэлтийн бус хөрөнгө
■ -1%	Бусад хөрөнгө		

Тайлант хугацаанд нийт эх үүсвэр 10.1 хувиар нэмэгдсэнтэй холбоотойгоор нийт актив өмнөх оны мөн үеэс 48.8 тэрбум төгрөгт хүрсэн нь банкны салбарын нийт активын 0.8 хувийг эзэлж байна.

Активын бүтцийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад дараах өөрчлөлт орсон байна. Чанаргүй зээлийн өрийн үлдэгдлийн нийт активт эзлэх хувийн жин 4.8-7.2 хувиар өссөн харагдаж байгаа хэдий ч нийт зээлийн хэмжээ өмнөх оны мөн үеийнхээс 2,645,740.4 мянган төгрөгөөр өссөнтэй харьцуулахад зээлийн чанар сайжирсан харагдаж байна. Харин хуримтлуулж тооцсон хүүгийн авлага 4.7-5.3 хувь болж өссөн үзүүлэлттэй байна.


Нийт орлогын хэмжээ 12.5 тэрбум төгрөг байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 13.9 хувиар буурсан, нийт зардлын хэмжээ 11.0 тэрбум төгрөг байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 37.3 хувиар тус тус буурсантай холбоотойгоор цэвэр ашиг 23.9 хувиар буурч 1.5 тэрбум төгрөг болжээ.

ХЗХ-ны ашигт ажиллагааны түвшинг илэрхийлсэн активын өгөөж (ROA) системийн дунджаар 5.3 хувь, өөрийн хөрөнгийн өгөөж /ROE/ 19.0 хувь байна.

### 4. Хоршоодын зээлийн багцын чанар

Нийт зээлийн өрийн үлдэгдэл өмнөх оны мөн үетэй харьцуулахад 8.2 хувиар өсч 34.9 тэрбум төгрөг болжээ.

Хугацаа хэтэрсэн зээлийн өрийн үлдэгдэл өмнөх оны мөн үеэс 7.8 хувиар буурч нийт зээлийн багцын 6.0 хувийг, чанаргүй зээлийн өрийн үлдэгдэл өмнөх оны мөн үеэс 4.6 хувиар буурч, нийт зээлийн багцын 10.1 хувийг тус тус эзэлж байна.



#### ХЗХ - ны зээлийн багцын чанар


■ 84%	Хэвийн зээл 29.2 тэрбум төгрөг
■ 6%	Хугацаа хэтэрсэн зээл 2.1 тэрбум төгрөг
■ 3%	Хэвийн бус зээл 0.9 тэрбум төгрөг
■ 2%	Эргэлзээтэй зээл 0.8 тэрбум төгрөг
■ 5%	Мүү зээл 1.8 төгрөг тэрбум



Зээлдэгчдийн төлбөрийн чадвар муудаж, зээлийн эргэн төлөлт удааширснаас чанаргүй зээлийн өрийн үлдэгдэл өмнөх оны мөн үетэй харьцуулахад 66.0 хувиар өсч, нийт зээлийн багцын 10.1 хувийг эзлэх болжээ.

Үүнтэй холбоотойгоор зээлийн эрсдэлийн сан өмнөх оны мөн үетэй харьцуулахад 38.0 хувиар өсч, нийт зээлийн багцад 2.5 тэрбум төгрөгийн зээлийн эрсдэлийн сан байгуулжээ.

## 5. ХЗХ-ны татан төвлөрүүлсэн хадгаламж, хувь нийлүүлсэн хөрөнгийн харьцаа



Гишүүдээс хадгаламж татан төвлөрүүлэх замаар санхүүгийн эх үүсвэрийг бүрдүүлэх, нэмэгдүүлэх сонирхол ХЗХ-д давамгайлж байдгаас ХЗХ-ны татан төвлөрүүлсэн хадгаламж, хувь нийлүүлсэн хөрөнгийн харьцаа тайлант хугацаанд 21.3 хувь байна. Гишүүдээс хоршоонд хадгалуулсан мөнгөн хадгаламжийн нийт дүн нь нийт активын 80 хүртэлх хувь байвал зохистой гэж үздэг бөгөөд энэ үзүүлэлт 71.3 хувь байна.

### 3.5. Хадгаламж зээлийн хоршооны талаарх эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох ажлын талаар

“Хадгаламж, зээлийн хоршооны тухай хуулийн төсөл, үзэл баримтлалыг боловсруулж УИХ-ын Эдийн засгийн байнгын хороонд хүргүүлсэн.

Хадгаламж, зээлийн хоршооны тухай хууль батлагдаж, түүнтэй нийцүүлж Хорооноос хадгаламж, зээлийн хоршооны үйл ажиллагааг дэмжих бодлогыг баримталснаар хадгаламж, зээлийн хоршоо нь нийгмийн чиг баримжаа, ардчилсан удирдлага, хамтын хяналттай, бие даасан тогтворжсон үйл ажиллагаатай, хүний нөөцийн чадвар, чадавхи нь бэхжсэн, нийгмийн эмзэг, дунд давхаргын санхүүгийн наад захын хэрэгцээг хангахуйц санхүүгийн бодит боломжтой салбар болон хөгжсөн байна гэж хөгжлийн цаашдын чиг хандлагыг Санхүүгийн зохицуулах хороо тодорхойлж байна.

Түүнчлэн хууль батлагдсанаар хадгаламж, зээлийн хоршооны үйл ажиллагаа олон улсын нийтлэг зарчимд нийцэх, цаашид тогтвортой хөгжих эрх зүйн орчин бүрдэх бөгөөд зөвхөн гишүүдийнхээ хүрээнд буюу тодорхой хүрээлэл бүхий иргэд, хуулийн этгээд сайн дураараа нэгдэн өөрсдийн санхүүгийн хэрэгцээг өөрсдийн хамтын эх үүсвэрээр хангах замаар эдийн засаг, нийгэм, соёлын нийтлэг хэрэгцээгээ хангах гэсэн энэхүү хуулийн зорилго биелж, хадгаламж, зээлийн хоршооны талаарх нийгмийн сэтгэл зүйн өөрчлөлтөд эерэг хандлага үзүүлж, санхүүгийн зах зээлийн хөгжилд нааштай үр дүн гарна гэж тооцож байна.

Санхүүгийн зохицуулах хорооноос баримтлах бодлого хэрэгжсэнээр хадгаламж, зээлийн хоршооны тогтвортой байдлыг хангах, бичил санхүүгийн зуучлалын дэд бүтэц өргөжих, цаашид санхүүгийн зах зээлд хямрал гарахгүй байх нөхцөл байдлыг бүрдүүлэх, иргэдийн хадгаламж, зээлийн хоршоонд итгэх итгэл дээшлэх, тэдгээрийн ашиг сонирхлыг хамгаалах арга замыг боловсронгуй болох, хадгаламж, зээлийн хоршоодоор дамжуулан хууль бус үйл ажиллагаа явуулах боломжийг хаах бололцоо бүрдэнэ.

### **3.6. Хадгаламж зээлийн хоршооны талаарх хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, хяналт шалгалт хийх ажлын талаар**

Хадгаламж, зээлийн хоршооны /цаашид ХЗХ гэх/ үйл ажиллагааны зохицуулалтын эрх зүйн орчинг тодорхой болгох, ХЗХ-ны санхүү, төлбөрийн чадварын тогтвортой байдлыг хангах, гишүүдийн эрх ашгийг хамгаалах, тэдгээрийн санхүүгийн боловсрол, мэдлэгийг сайжруулах, мэдээллээр хангах бодлогыг баримтлан ажиллалаа.

ХЗХ-ны санхүү, төлбөрийн чадварт тавих зайны болон газар дээрх хяналт, шалгалтыг тогтмолжуулах, тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлагыг хангуулах чиглэлээр дараах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлж ажиллалаа.

ХЗХ-ны санхүү, төлбөрийн тогтвортой байдлыг хангах, үйл ажиллагаанд нь учирч болзошгүй эрсдэлээс сэргийлэх, тооцоолох, илэрсэн зөрчлийг арилгуулах зорилгоор нийт 63 ХЗХ-ны үйл ажиллагаанд газар дээрх шалгалтыг гүйцэтгэж илэрсэн нийтлэг зөрчилд дүгнэлт хийж, нэгдсэн танилцуулгыг Хороонд танилцуулан шаардлагатай асуудлаар зохих шийдвэрийг гаргаж ажилласан байна.

Газар дээрх шалгалтаар илэрсэн зөрчилд холбогдох хууль тогтоомж болон эрх бүхий төрийн байгууллагаас баталж гаргасан журам зааврыг зөрчсөн 7 ХЗХ-нд нийт 550.0 мянган төгрөгийн торгууль ногдуулж, 35 ХЗХ-нд Улсын байцаагчийн албан шаардлагаар зөрчил арилгах тодорхой үүрэг, даалгавар өгч, биелэлтэд нь тогтмол хяналт тавьж ажиллалаа.

Тайлант онд ХЗХ-ны үйл ажиллагаанд зайнаас тавих хяналтыг тогтмолжуулж, ирүүлсэн улирлын санхүүгийн тайлан тэнцлийг хянаж, илэрсэн дутагдлыг арилгах талаар давхардсан тоогоор нийт 505 тайлангийн хариугаар ХЗХ-нд цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар хугацаатай үүрэг, даалгавар өгч, биелэлтэд нь хяналт тавьж ажиллав.

ХЗХ-ны ирүүлсэн улирал бүрийн санхүүгийн тайлан, тэнцлийг нэгтгэн, 2009 оны 4 дүгээр, 2010 оны 1, 2, 3 дугаар улирлын санхүүгийн тайлангийн нэгтгэлийг хийж, статистик дүн шинжилгээ, үнэлэлт, дүгнэлтийн нэгдсэн танилцуулгыг Хорооны удирдлагуудад танилцуулж, холбогдох мэдээллийг Хорооны цахим хуудаст байршуулан ажиллалаа.

Тайлант хугацаанд хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл хүссэн 2 хоршоонд олгож, Хоршооны тухай болон бусад холбогдох хууль, тогтоомж, тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлагыг биелүүлээгүй нийт 35 ХЗХ-ны хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосноор нийт 179 хоршоо хадгаламж, зээлийн үйл ажиллагааг тусгай зөвшөөрөлтэй эрхэлж байна.

Хоршооны тухай болон холбогдох бусад хууль, тогтоомж, журмын нөхцөл, шаардлагыг удаа дараа биелүүлээгүй 15 ХЗХ-ны тусгай зөвшөөрлийг 3 сарын хугацаатай түдгэлзүүлж, түдгэлзүүлсэн хугацаанд гаргасан зөрчлийг арилгаж, Хороонд тусгай зөвшөөрлийг сэргээх тухай хүсэлтээ ирүүлсэн 4 ХЗХ-ны тусгай зөвшөөрлийг сэргээсэн.

Мөн тайлант хугацаанд хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн хугацаа сунгуулах хүсэлтээ ирүүлсэн 80 ХЗХ-ны хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг сунгасан байна.

Улсын бүртгэлд бүртгэлтэй боловч Хорооноос хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл аваагүй, үйл ажиллагаа нь зогсож, санхүү болон төлбөрийн чадваргүй болсон Монгол газар гоулд, Зиндаа инвест хоршооны удирдлагад үүрэг өгч ажиллан Зиндаа инвест хоршооны асуудлыг Улсын мөрдөн байцаах газарт шилжүүлсэн.

### **3.7. Бичил санхүүгийн салбарыг сурталчлах, иргэдийн санхүүгийн боловсролыг дээшлүүлэх ажлын талаар**

Санхүүгийн зах зээлийн хөгжил, цаашдын тогтвортой байдлыг хангахад иргэдийн санхүүгийн мэдлэгийг дээшлүүлэх, ББСБ, ХЗХ-ны үйл ажиллагаатай холбогдсон мэдээллийн ил тод, шуурхай байдлыг хангах зорилгоор энэ зах зээлийн зохицуулалтыг хэрэгжүүлэхийн тулд авч байгаа бодлогын арга хэмжээ, хүчин төгөлдөр мөрдөгдөж буй журам, заавар болон тусгай зөвшөөрөл авсан буюу тусгай зөвшөөрлийг нь түдгэлзүүлсэн, сэргээсэн, хүчингүй болгосон хуулийн этгээдийн талаар Хорооны цахим-хуудас, хэвлэл, мэдээллийн хэрэгслээр дамжуулан олон нийтэд хүргэж, холбогдох төрийн байгууллагуудад албан тоотоор хүргүүлэн ажиллалаа.

Бичил санхүүгийн салбарын үйл ажиллагааны талаарх мэдээ, мэдээллийг ил тод болгож олон нийтэд түргэн шуурхай хүргэх ажлын хүрээнд ББСБ, ХЗХ-ны улирал бүрийн санхүүгийн тайлангийн нэгтгэлийн холбогдох мэдээллийг Хорооны цахим хуудаст байршуулж, Монголын банк бус санхүүгийн байгууллагуудын холбоо болон Монголын хадгаламж, зээлийн хоршоодын холбоонд тогтмол хүргүүлж байна.

Бичил санхүүгийн байгууллагын удирдах болон гүйцэтгэх ажилтны ур чадвар, чадавхийг дээшлүүлэх нь салбарын хөгжил, тухайн байгууллагын хэвийн үйл ажиллагаа, эрсдэлийг бууруулахад нөлөөлөх чухал хүчин зүйл тул өнгөрсөн онд санхүүгийн чиглэлээр зохион байгуулагдсан гадаад дотоодын сургалт, семинар, зөвлөгөөнд мэргэжлийн байгууллагын боловсон хүчнийг өргөнөөр хамруулахад ихээхэн анхаарал тавьж дараахь ажлуудыг хийж гүйцэтгэсэн.:

Хорооны санаачлагаар “Тогтвортой амьжиргаа-II” төслийн Бичил санхүүгийн хөгжлийн сангийн санхүүгийн дэмжлэгтэйгээр тусгайлан багш уригдан менежерүүд болон зарим хянан шалгагчдад зориулсан эрсдэлийн удирдлагын чиглэлээр ахисан түвшиний 2 өдрийн сургалтыг зохион байгуулсан.

Монголбанкнаас зохион байгуулсан Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах зорилго бүхий “Банкнаас бусад мэдээлэх үүрэгтэй этгээдийн хэрэгжилт хариуцсан ажилтанд зориулсан сургалт”-д 126 ББСБ-уудын төлөөллийг хамруулсан.

Хороо бичил санхүүгийн салбарын зохицуулалтыг сайжруулах ажлын хүрээнд МББСБХ болон МХЗХХ-той Харилцан ойлголцлын санамж бичгийг 2010 онд байгуулан ажиллаж байна.

Канадын хоршоодын холбоо, Монголын хадгаламж, зээлийн хоршоодын холбоо, Монголын хоршооллын сургалт, мэдээллийн төвөөс Орхон аймагт хамтран зохион байгуулсан “ХЗХ-дын сургалт, түршлага солилцох өдөрлөг”-т нийт 53 ХЗХ-ны удирдлагыг оролцуулан зохион байгуулж, ХЗХ-ны өнөөгийн байдлын талаар мэдээлэл хийж, “Зохистой харьцааны шалгуур үзүүлэлт”-ийн талаар хичээл заалаа.

Канадын хоршоодын холбооны 9 төлөөлөгч ирж 7 ХЗХ-ны ажилтай танилцаж, зөвлөгөө өгсөн ба Хорооны удирдлагатай уулзаж, ХЗХ-ын тухай хуулийн төсөлд зөвлөгөө өгч ажилласан байна.

Монголын хоршооллын сургалт, мэдээллийн төвөөс төлөвлөгөөний дагуу нийт 15 удаагийн сургалт зохион байгуулсан ба 65 ХЗХ-ны 200 ажилтан, удирдлага оролцсон сургалтуудад газрын төлөөлөл тогтмол оролцож, ХЗХ-ын үйл ажиллагааны талаарх болон Хорооноос авч хэрэгжүүлж буй арга хэмжээний талаар мэдээллээр хангаж ажиллалаа.

Хорооноос ББСБ-ын гүйцэтгэх удирдлагад зориулсан сургалт, семинарыг 2010 оны 12 дугаар сарын 13-ны өдөр МҮХАҮТ-ын хурлын танхимд зохион байгуулж нийт 86 ББСБ-ын удирдлага оролцож, санал бодлоо солилцсон байна.

Казахстан Улс, Польш Улсын Бичил санхүүгийн төвөөс зохион байгуулсан “Хямралын дараах бичил санхүү. Дараагийн алхам юу вэ?” сэдэвт жилийн хуралд 9 ББСБ-ын удирдах ажилтнуудыг хамрууллаа.

“Бичил санхүү-Тогтвортой амьжиргааны тулгуур” сэдэвт эрдэм шинжилгээний бүтээлийн уралдааныг БСХС-тай хамтран 2 шаттайгаар зарлаж, дүгнэж, шалгаруулан холбогдох мэдээллийг Хорооны цахим хуудаст байрлууллаа.

Монголбанкны Зээлийн мэдээллийн сангийн системд бичил санхүүгийн салбарын зээлдэгчдийн мэдээлэл бүрэн хамрагддаггүй байдлыг багасгах болон бичил санхүүгийн байгууллагын зээлийн эрсдэлтэй холбоотой сөрөг үр дагаварыг бууруулах зүй ёсны шаардлага гарч байгаатай уялдуулан ББСБ-ыг Монголбанкны зээлдэгчдийн талаарх мэдээлэл цуглуулах шинэ системд заавал хамруулж байх зохицуулалтын асуудлыг хамтран шийдвэрлэх ажлын хүрээнд Монголбанкт хамтран «Монголбанкны зээлийн мэдээллийн санд мэдээлэл хэрхэн нийлүүлэх тухай» сэдэвт сургалт зохион байгуулж, 88 ББСБ-ын 115 хүнийг оролцуулсан байна.

Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй санхүүгийн байгууллага Монголбанкны Зээлийн мэдээллийн санд зээлдэгчдийн талаарх мэдээллийг нийлүүлэх, холбогдох мэдээллийг авахад ашиглагдах санхүүгийн программ хангамжийн асуудлыг цэгцлэх, тэдгээрийг нэгдсэн программаар хангах, Зээлийн мэдээллийн нэгдсэн сантай болгох зорилгоор Бичил санхүүгийн хөгжлийн сан, Санхүүгийн зохицуулах хороо, Юу Эс Ай ХХК-тай хамтран ажиллахаар тохиролцож Хамтын ажиллагааны гэрээг тус тус байгуулсан.

Харилцагчдын хөрөнгийг эрсдлээс хамгаалах чиглэлээр Монгол банкт хамтран ажиллаж тус банкны Зээлийн мэдээллийн санд ББСБ, ХЗХ-дын талаарх мэдээлэл цуглуулах системд хамруулан ажиллаж байна

## ДӨРӨВ. ДААТГАЛЫН ЗАХ ЗЭЭЛИЙН ТАЛААР


### 4.1. Даатгалын зах зээлийн өнөөгийн байдал

Тайлант онд даатгалын зах зээл дээр 17 даатгалын компани, 2061 даатгалын төлөөлөгч, 9 даатгалын зуучлагч, 6 даатгалын хохирол үнэлэгч, 12 актуарч, нийт 2105 даатгалын тусгай зөвшөөрөл, эрх эзэмшигчид үйл ажиллагаа явуулсан байна.

Даатгалын зах зээл дээрх тусгай зөвшөөрөл, эрх эзэмшигчид


№		2007 он	2008 он	2009 он	2010 он
1	Даатгагч /Даатгалын компанийн салбар/	15 /91/	16 /120/	18 /129/	17 /138/
2	Даатгалын төлөөлөгч	690	1 167	1 676	2061
3	Даатгалын зуучлагч	2	4	5	9
4	Даатгалын хохирол үнэлэгч	-	-	2	6
5	Актуарч	-	9	10	12
	<b>Бүгд</b>	<b>707</b>	<b>1196</b>	<b>1711</b>	<b>2105</b>

Даатгалын зах зээл дээрх тусгай зөвшөөрөл эзэмшигчид тоогоор



Даатгалын зах зээл дээр үйл ажиллагаа явуулахаар тусгай зөвшөөрөл авсан хуулийн этгээд, хувь хүмүүсийн тоо 2007 оноос 2010 оны хооронд 3,0 дахин өссөн ба 2009 оноос 2010 оны хооронд 394 тусгай зөвшөөрөл эзэмшигчдээр нэмэгдэж даатгалын зах зээлийн өсөлтийн хурдацыг харуулж байна.

2010 оны байдлаар даатгалын зах зээл дээр урт хугацааны болон ердийн даатгалын үйл ажиллагаа явуулж буй даатгалын компаниудын нийт хөрөнгө 56,7 тэрбум төгрөгт хүрч өмнөх 2009 оныхоос 15,6 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн байна. Хорооны 2009 оны 153 дугаар тогтоолоор 2011 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс “Ердийн даатгалын үйл ажиллагаа эрхлэх даатгалын компанийн дүрмийн сангийн доод хэмжээг 1 тэрбум төгрөг, урт хугацааны даатгалын үйл ажиллагаа эрхлэх даатгалын компанийн дүрмийн сангийн доод хэмжээг 2 тэрбум төгрөг” байхаар баталсантай холбоотой даатгалын компаниудын нийт хөрөнгө огцом нэмэгдэж, 2010 онд 2003 оноос хойш 4,4 дахин өссөн дүнтэй байгааг доорхи графикаас харж болно.



2010 онд даатгалын компаниудыг нийт хөрөнгийн хэмжээгээр жагсаахад “Монгол даатгал” ХХК 16,1 тэрбум төгрөгийн хөрөнгөтэй буюу нийт зах зээлийн 28,3 хувийг эзэлж даатгалын салбарыг нийт хөрөнгийн хэмжээгээрээ тэргүүлж байгаа бол “Моннис даатгал” ХХК 1,0 тэрбум төгрөгийн хөрөнгөтэйгээр нийт зах зээлийн 1,8 хувийг эзэлж байна.


**Даатгалын компаниудын хөрөнгийн хэмжээ**

/сая төгрөгөөр/

№	Даатгалын компаниуд	Нийт хөрөнгийн хэмжээ	Эзлэх хувь
1	Монгол даатгал ХХК	16 058,3	28,3
2	Бодь даатгал ХХК	5 072,0	8,9
3	Тэнгэр даатгал ХХК	4 310,2	7,6
4	Практикал даатгал ХХК	4 184,2	7,4
5	Миг даатгал ХХК	4 103,5	7,2
6	Номин даатгал ХХК	3 029,1	5,3
7	Ард даатгал ХХК	2 982,9	5,3
8	Соёмбо даатгал ХХК	2 437,6	4,3
9	Нэйшнл лайф даатгал ХХК	2 142,7	3,8
10	Ган зам даатгал ХХК	2 031,8	3,6
11	УБ даатгал ХХК	1 695,1	3,0
12	Монгол траст холдинг даатгал ХХК	1 677,5	3,0
13	УБ хотын даатгал ХХК	1 655,6	2,9
14	Мөнх даатгал ХХК	1 526,5	2,7
15	Жонон даатгал ХХК	1 408,5	2,5
16	Гранд даатгал ХХК	1 402,3	2,5
17	Моннис даатгал ХХК	1 046,1	1,8
	<b>Дүн</b>	<b>56 763,9</b>	<b>100,0</b>


Нийт хөрөнгөнд эргэлтийн хөрөнгийн эзлэх хувь өндөр байгаагийн гол шалтгаан нь Хорооны 2008 оны 242 дугаар тогтоолоор батлагдсан “Даатгагчийн дүрмийн сан болон нөөц сангаас хөрөнгө оруулалт хийхэд тавигдах шаардлага” журмаар дүрмийн болон нөөц сангийн хөрөнгийг мөнгө ба түүнтэй адилтгах хэлбэрээр байршуулах шаардлага давамгайлж байсантай холбоотой байна. 2010 онд мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн хэмжээ, богино хугацаат хөрөнгө оруулалт нийт 42.8 тэрбум төгрөг байгаа бөгөөд нийт эргэлтийн хөрөнгийн 90.0 хувийг эзэлж, тайлант онд өмнөх оны мөн үеийнхээс 3.7 пунктээр өссөн байна. Эргэлтийн хөрөнгийн нийт хөрөнгөнд эзлэх хувь хэмжээ өссөн нь 2009 оны 232 дугаар тогтоолоор батлагдсан “Ердийн даатгалын нөөц сан бүрдүүлэх, зарцуулах, түүнд хяналт тавих журам”, мөн 2010 оны 170 дугаар тогтоол “Ердийн даатгалын компанийн хөрөнгийн байршил, хөрөнгө оруулалт, түүнд тавигдах шаардлага”-ын хэрэгжилттэй холбоотой юм.

### Эргэлтийн болон эргэлтийн бус хөрөнгийн харьцаа



Даатгалын компаниудын нийт өр төлбөр ба эзэмшигчдийн өмчид даатгалын нөөц сан, эзэмшигчдийн өмч, өр төлбөрийн эзлэх хувь хэмжээг сүүлийн 4 жилийн байдлаар дүгнэж үзэхэд 2005-2007 онуудад эзэмшигчдийн өмч дунджаар 37,2 хувь, нөөцийн сан 56,7 хувь, нийт өр төлбөр 6,1 хувийг тус тус эзэлж байсан бол 2008 онд энэхүү бүтцэд нилээд өөрчлөлт гарч нөөцийн сан 43,8 хувь болж 18,9 пунктээр буурч, харин нийт өр төлбөр 18,9 пунктээр өссөн нь дараахь графикаас харагдаж байна.

### Өр төлбөр, эзэмшигчдийн өмч, нөөц сангийн харьцаа



Энэ нь Хорооны 2008 оны 241 дүгээр тогтоолоор батлагдсан “Даатгалын байгууллагын мэдээллийн сангийн журам”-ын хавсралтын дагуу орлогод тооцоогүй хураамжийн нөөцийн санг балансын нөөцийн сангийн хэсгээс хасч, өр төлбөр хэсэг дэх урьдчилж орсон орлогоор бүртгэх

болсонтой холбоотой байсан. Энэхүү “Даатгалын байгууллагын мэдээллийн сангийн журам”-ыг сайжруулан боловсруулж “Даатгагч болон даатгалын мэргэжлийн оролцогчийн санхүүгийн нэмэлт тайлангийн агуулга, маягтыг тогтоох журам” болгон Хорооны 2009 оны 275 дугаар тогтоолоор баталсан. Шинээр боловсруулсан энэхүү журмын дагуу орлогод тооцоогүй хураамж нь балансын “нөөц сан” гэсэн үзүүлэлтэнд орохоор болсон учраас 2009 онд нийт өр төлбөр, эзэмшигчдийн өмчид өр төлбөрийн эзлэх хувь өмнөх онтой харьцуулахад огцом буурсан дүр зураг харагдаж байсан.

Үзүүлэлт	2006	Хувь	2007	Хувь	2008	Хувь	2009	Хувь	2010	Хувь
Өр төлбөр	1153.6	5.6	1785.3	6.3	8666.2	25.2	2390.5	5.8	2446.9	4.3
Нөөц сан	12198.3	58.7	17784.4	62.7	15033.9	43.8	24744.6	60.3	29174.7	51.4
Эзэмшигчийн өмч	7433.3	35.8	8808.2	31.0	10630.1	31.0	13920.6	33.9	25142.3	44.3
Нийт дүн	20785.2	100.0	28377.9	100.0	34330.2	100.0	41055.7	100.0	56763.9	100.0

Эзэмшигчдийн өмчийн нийт өр төлбөр, эзэмшигчдийн өмчид эзлэх хувь 2009 онд 33,9 хувь байсан бол 2010 онд 44,3 хувь болж өмнөх оныхоос 10,4 пунктээр өсч, мөн нөөц сан 2009 онд 60,3 хувь байсан бол тайлант онд 51,3 хувь болж өмнөх оныхоос 8,9 пунктээр буурсан байна. 2009 онд эзэмшигчийн өмч нийт өр төлбөрийн 5,8 хувийг эзэлж байсан бол 2010 онд 4,3 хувийг эзэлж 1,5 пунктээр өссөн үзүүлэлт ажиглагдаж байна.


Эзэмшигчийн өмчийн өсөлт нь Хорооны 2009 оны 153 дугаар тогтоолоор 2011 оноос “Ердийн даатгалын үйл ажиллагаа эрхлэх даатгалын компанийн дүрмийн сангийн доод хэмжээг 1 тэрбум төгрөг, урт хугацааны даатгалын үйл ажиллагаа эрхлэх даатгалын компанийн дүрмийн сангийн доод хэмжээг 2 тэрбум төгрөг” байхаар баталсантай холбоотой юм.

### Даатгалын хураамжийн орлого

2010 онд даатгалын зах зээл дээр үйл ажиллагаа явуулсан ердийн даатгагч болон урт хугацааны даатгалын компанийн нийт орлого 31,8 тэрбум төгрөг байна. Үүнээс ердийн даатгалын хураамжийн орлого 31,5 тэрбум төгрөг, урт хугацааны даатгалын компанийн орлого 0,3 тэрбум төгрөг байна.

Тайлант онд ердийн даатгалын компанийн давхар даатгалын хураамж 7,5 тэрбум төгрөг, буцаасан даатгалын хураамж 0,2 тэрбум төгрөг, даатгалын цэвэр хураамжийн орлого 23,8 тэрбум төгрөгт хүрсэн байна. Урт хугацааны даатгалын компанийн хувьд давхар даатгалын хураамж 0,1 тэрбум төгрөг, даатгалын цэвэр хураамжийн орлого нь 0,2 тэрбум төгрөг байна

Даатгалын хураамжийн орлого /тэрбум төгрөг/




2001 оноос 2010 он хүртэлх хугацаанд даатгалын нийт орлого 26.63 тэрбум төгрөгөөр өссөн үзүүлэлт харагдаж байгаа бөгөөд 2009 оны мөн үеийнхээс 8.4 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн нь даатгалын хураамжийн орлого төвлөрүүлэлтэнд өсөх хандлага ажиглагдаж байгааг харуулахаас гадна даатгуулагчдын тоо өссөнтэй холбоотой юм.

2010 оны даатгалын нийт хураамжийн орлогыг ердийн болон урт хугацааны даатгалын хэлбэрээр нарийвчлан харахад өмнөх оны мөн үеийнхээс хөрөнгийн даатгал 1796,4 сая төгрөгөөр, авто тээврийн хэрэгслийн даатгал 2142,7 сая төгрөгөөр, хариуцлагын даатгал 1578,4 сая төгрөгөөр, гэнэтийн осол эмчилгээний зардлын даатгал 1072,8 сая төгрөгөөр, авто тээврийн хэрэгслийн жолоочийн хариуцлагын даатгал 242,8 сая төгрөгөөр, санхүүгийн даатгал 686,9 сая төгрөгөөр, барилга угсралтын даатгал 974,1 сая төгрөгөөр, ачааны даатгал 390,6 сая төгрөгөөр, эрүүл мэндийн даатгал 36,1 сая төгрөгөөр, мал амьтадын даатгал 55,8 сая төгрөгөөр, хуримтлалын даатгал 1,0 сая төгрөгөөр тус тус нэмэгдэж, нийт 8368,9 сая төгрөгөөр өмнөх оны мөн үеийнхээс өссөн үзүүлэлттэй харагдаж байна.

/сая төгрөгөөр/

Даатгалын хэлбэр	2009.12.31	2010.12.31	Өөрчлөлт /+, -/
	Даатгалын хураамжийн орлого	Даатгалын хураамжийн орлого	
1.2. Хөрөнгийн даатгал	6 450,4	8246,8	1796,4
1.3. Авто тээвэр хэрэгслийн даатгал	4 771,4	6914,1	2142,7
1.8. Агаарын хөлгийн даатгал	3 082,9	2342,6	-740,3
1.10. Хариуцлагын даатгал	3 078,6	4657	1578,4
1.1. Гэнэтийн осол, эмчилгээний зардлын даатгал	2 676,9	3749,7	1072,8
1.9. Автотээврийн хэрэгслийн жолоочийн хариуцлагын даатгал	1 827,7	2070,5	242,8
1.11. Санхүүгийн даатгал	611,8	1298,7	686,9
1.5. Барилга угсралтын даатгал	394,7	1368,8	974,1
1.4. Ачааны даатгал	375,2	765,8	390,6
2.1. Хугацаат амьдралын даатгал	59,5	191,8	132,3
2.5. Эрүүл мэндийн даатгал	55,4	91,5	36,1
1.7. Мал амьтдын даатгал	13,5	69,3	55,8
1.6. Газар тариалангийн даатгал	1,3	0	-1,3
2.3. Хуримтлалын даатгал	0,3	1,3	1,0
2.4 Тэтгэврийн даатгал	0,0	0,6	0,6
<b>Дүн</b>	<b>23 399,6</b>	<b>31 768,5</b>	<b>8 368,9</b>


Даатгалын нийт хураамжийн орлогын хэмжээг ДНБ-тэй харьцуулахад 2001 оноос 2010 оны хооронд 0,32 хувиас 0,43 хувийн хооронд хэлбэлзэж ирсэн байна. Монгол Улсын эдийн засгийн өсөлт болон бусад томоохон салбаруудын эдийн засгийн өсөлт, бууралтын нөлөөлөлтэй холбоотойгоор даатгалын нийт хураамжийн орлого ДНБ-д маш бага хувь эзэлж байна. Нийт хураамжийн орлогын ДНБ-д эзлэх хувь 2009 онд 0,39 хувь байсан бол мөн 2010 оны байдлаар 0,39 хувь байна.





2008 онд нэг хүнд ногдох даатгалын хураамжийн орлого 7977,6 мянган төгрөг байсан бол 2009 онд 8657,1 мянган төгрөг, 2010 онд 11766,1 мянган төгрөг болж өмнөх оны мөн үеийнхээс 3109,0 мянган төгрөгөөр өссөн байна.


#### Нэг хүнд ногдох даатгалын хураамжийн орлого /мянган төгрөгөөр/



#### Даатгалын нөхөн төлбөр

2010 онд даатгалын компаниуд даатгуулагч иргэд, байгууллагуудад нийт 6,8 тэрбум төгрөгийн нөхөн төлбөр олгосон нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1,3 тэрбум төгрөгөөр өссөн байна.

#### Даатгалын нөхөн төлбөр



Даатгалын хураамжийн орлого болон олгосон нөхөн төлбөрийн хэмжээг сүүлийн 10 жилийн байдлаар хооронд нь зэрэгцүүлэхэд 2003 оноос хойш олгосон нөхөн төлбөрийн хэмжээ хураамжийн орлогыг даган өсөх болсон боловч олгосон нөхөн төлбөрийн өсөлтийн хурдац хураамжийн орлогын жилийн өсөлтийн хурдацаас нилээд доогуур байсан учраас 2010 он гэхэд хураамжийн орлого, олгосон нөхөн төлбөрийн хоорондын зөрүү нилээд нэмэгдсэн байна. Даатгалын нөхөн төлбөр 2001 оноос хойш даатгалын нөхөн төлбөр нийт 5,0 тэрбумаар өссөн үзүүлэлттэй ажиглагдаж байна.

Даатгалын хэлбэр	Даатгалын нөхөн төлбөр (сая төг)	Эзлэх хувь
1.2. Хөрөнгийн даатгал	1 425,5	20,90
1.3. Авто тээвэр хэрэгслийн даатгал	3 022,3	44,31
1.8. Агаарын хөлгийн даатгал	10,4	0,15
1.10. Хариуцлагын даатгал	224,1	3,29
1.1. Гэнэтийн осол, эмчилгээний зардлын даатгал	776,5	11,38
1.9. Авто тээврийн хэрэгслийн жолоочийн хариуцлагын даатгал	757,9	11,11
1.11. Санхүүгийн даатгал	419,6	6,15
1.5. Барилга угсралтын даатгал	89,0	1,30
1.4. Ачааны даатгал	38,4	0,56
2.1. Хугацаат амьдралын даатгал	15,0	0,22
2.5. Эрүүл мэндийн даатгал	30,7	0,45
1.7. Мал амьтдын даатгал	11,4	0,17
1.6. Газар тариалангийн даатгал		0,00
2.3. Хуримтлалын даатгал		0,00
<b>Дүн</b>	<b>6 820,8</b>	<b>100,0</b>

2009 онд олгосон даатгалын нөхөн төлбөрийг даатгалын хэлбэр тус бүрээр харьцуулж үзвэл автотээврийн хэрэгслийн даатгал нийт нөхөн төлбөрийн 48,7 хувийг эзэлж байгаа бол үүний дараа хөрөнгийн даатгал 19,4 хувь, автотээврийн хэрэгслийн жолоочийн хариуцлагын даатгал 11,6 хувийг тус тус эзэлж байсан бөгөөд, 2010 онд нийт нөхөн төлбөрийн 44,3 хувийг авто тээврийн хэрэгслийн жолоочийн хариуцлагын даатгал эзэлж байгаа бөгөөд 20,9 хувийг хөрөнгийн даатгал эзэлж байгаа бөгөөд 11,38 хувийг гэнэтийн осол, эмчилгээний зардлын даатгал, 11,1 хувийг авто тээврийн хэрэгслийн жолоочийн хариуцлагын даатгал тус тус эзэлж байна. Харин газар тариалангийн даатгал, мал амьтдын даатгалаар нөхөн төлбөр олгогдоогүй байна.

2010 онд даатгалын нөхөн төлбөр 6,8 тэрбум төгрөг болсон бөгөөд нөхөн төлбөр хураамжийн орлогын харьцаа 21,4 хувь байна. Өмнөх оны энэ харьцаа 23,5 хувь байсан ба энэхүү бууралтын шалтгаан нь хураамжийн орлого 1,2 дахин өссөн байхад даатгалын нөхөн төлбөр 1,4 дахин нэмэгдсэнтэй холбоотой байна.

### Нөхөн төлбөр хураамжийн орлого




2007 онд даатгалын хохирол нөхөлтийн харьцаа 43,8 хувь, 2008 онд 30,4 хувь, 2009 онд 33,5 хувь, 2010 онд 34,0 хувь хүрч өмнөх оны мөн үеийнхээс 0,5 пунктээр өссөн байна.



### Ашигт ажиллагаа

Даатгалын салбарын хэмжээгээр 2006 онд 1187,0 сая төгрөг, 2007 онд 303,4 сая, 2008 онд 102,9 сая төгрөгийн хуримтлагдсан алдагдалтай ажиллаж байсан бөгөөд 2009 онд хуримтлагдсан алдагдалгүй болж 1779,0 сая төгрөг, 2010 онд 3332,6 сая төгрөгийн хуримтлагдсан ашигтай ажилласан байна. Тайлант оны хуримтлагдсан ашиг өмнөх оны мөн үеийнхээс 1553,6 сая төгрөгөөр өссөн байгаа нь 4760,0 сая төгрөгийн цэвэр ашигтай ажилласантай холбоотой юм.


Үзүүлэлт	2006	2007	2008	2009	2010
Хуримтлагдсан ашиг (алдагдал)	- 1 187.0	- 303.4	- 102.9	1 779.0	3 332.6



Даатгалын салбарын хэмжээгээр 2009 онд даатгалын компаниуд нийт 2,4 тэрбум төгрөгийн тайлант үеийн цэвэр ашигтай ажилласан бол 2010 онд 4,7 тэрбум төгрөг болсон нь өмнөх онтой харьцуулахад 2 дахин буюу 2,3 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн байна.

## Даатгалын нөөц сан


Даатгалын нөөц сангийн үлдэгдлийг сүүлийн 5 жилийн байдлаар зэрэгцүүлж үзэхэд тогтвортой өсч байсан дүр зураг харагдаж байна. 2009 онд даатгалын нөөц сангийн хэмжээ 24,7 тэрбум төгрөгт хүрч өмнөх оны мөн үеийнхээс 1.2 дахин буюу 4.4 тэрбум төгрөгөөр өссөн байна.



Нийт нөөц сангийн үлдэгдэл 29174,7 сая төгрөг байгаагаас ердийн даатгалын компанийн нөөц сангийн үлдэгдэл 29081,5 сая төгрөг байгаа бөгөөд урт хугацааны даатгалын 93,2 сая төгрөг байна.

## Давхар даатгал

2009 онд “Ард даатгал” ХХК, “Бодь даатгал” ХХК, “Миг даатгал” ХХК, “Монгол даатгал” ХХК, “Номин даатгал” ХХК, “Прайм генерал даатгал” ХХК, “Практикал даатгал” ХХК, “Нэйшнл лайф даатгал” ХХК-иуд даатгалын эрсдэлээ давхар даатгуулж, нийт 6,0 тэрбум төгрөгийн давхар даатгалын хураамжийг төлсөн байсан бол 2010 онд “Ард даатгал” ХХК, “Бодь даатгал” ХХК, “Миг даатгал” ХХК, “Монгол даатгал” ХХК, “Номин даатгал” ХХК, “Тэнгэр даатгал” ХХК, “Практикал даатгал” ХХК, “Нэйшнл лайф даатгал” ХХК-иуд нь 7,5 тэрбум төгрөгийг төлсөн нь өмнөх оны мөн үеийнхээс 1,5 тэрбум төгрөгөөр өссөн байна.



### Даатгалын зуучлагч компаниуд

2007 онд даатгалын зуучлагч компани 2, 2008 онд 4, 2009 онд 5, 2010 онд 9 компани үйл ажиллагаагаа явуулж байна. 2010 онд шинээр “Ренессанс групп” ХХК, “Лоялти солюшн” ХХК, “Жомолхари” ХХК, “Монголиан интернэшнл брокерс” ХХК-иуд шинээр тусгай зөвшөөрөл авсан.

2010 онд даатгалын зуучлагчийн тусгай зөвшөөрөл эзэмшигч компаниудын үндсэн үйл ажиллагааны орлого 193,6 сая төгрөг болсон бөгөөд үүнээс даатгалын зуучлалын орлого 177,3 сая төгрөг, бусад орлого 16,3 сая төгрөг төвлөрүүлсэн байна.

д/д	Даатгалын зуучлагч компанийн нэр	Даатгалын зуучлалын орлого	Эзлэх хувь хэмжээ
1	“Асимон брокерс” ХХК	35,8	20,2
2	“АМЕ” ХХК	23,5	13,3
3	“Ачит ундарга” ХХК	24,9	14,0
4	“Лоялти солюшн” ХХК	34,6	19,5
5	“Эм Жи Ай Би” ХХК	23,8	13,4
6	“Скай-Эрдэнэ” ХХК	22,7	12,8
7	“Ренессанс групп” ХХК	12,0	6,8
8	“Жомолхари” ХХК	0	Үйл ажиллагаа явуулаагүй
9	“Монголиан интернэшнл” ХХК	0	Үйл ажиллагаа явуулаагүй
	<b>Дүн</b>	<b>177,3</b>	<b>100,0</b>

“Асимон брокерс” ХХК нь даатгалын зуучлалын орлогын 20,2 хувийг эзэлж тэргүүлсэн бол “Лоялти солюшн” ХХК 19,5 хувь эзэлж, нийт зах зээлийн 40,0 хувийн орлогыг эдгээр даатгалын зуучлагчид эзэлсэн байна.

### Даатгалын хохирол үнэлэгч компаниуд

2009 онд 2 даатгалын хохирол үнэлэгч байсан бол 2010 онд шинээр 4 компани нэмэгдсэн байна. “Вендо” ХХК, “Гэрэгэ эстимэйт” ХХК, “Файн эстимэйт” ХХК, “Мега марз” ХХК-иуд тусгай зөвшөөрлөө шинээр авсан байна.

Даатгалын хохирол үнэлэгч компаниуд 2010 онд нийт үндсэн үйл ажиллагааны орлого 119,9 сая төгрөг, үүнээс даатгалын хохирол үнэлгээний орлого 36,0 сая төгрөг, бусад орлого 83,9 сая төгрөг олсон байна.

д/д	Даатгалын хохирол үнэлэгч компанийн нэр	Даатгалын хохирол үнэлгээний орлого	Эзлэх хувь хэмжээ
1	“Бест эстимэйт” ХХК	14,3	39,7
2	“Гэрэгэ эстимэйт” ХХК	4,9	13,6
3	“Файн эстимэйт” ХХК	3,5	9,8
4	“Итгэлт эстимэйт” ХХК	7,9	21,9
5	“Мега марз” ХХК	5,4	15,0
6	“Вендо” ХХК	0	Тайлан ирүүлээгүй
	<b>Нийт дүн</b>	<b>36,0</b>	<b>100,0</b>

2009 онд тусгай зөвшөөрлөө авсан “Бест эстимэйт” ХХК, “Итгэлт эстимэйт” ХХК-иуд нийт даатгалын хохирол үнэлгээний орлогын 61,6 хувийг эзэлж байгаа бөгөөд эдгээр компаниуд нь бусад хохирол үнэлэгч компаниудыг бодвол үйл ажиллагаа нь жигдэрч эхэлсэн байна.

## **4.2. Даатгалын талаарх эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох ажлын талаар**

Даатгалын зах зээлийг хөгжүүлэх бодлогын хүрээнд хариуцлагын заавал даатгалын тогтолцоог шинээр бий болгоход анхаарч, “Автотээврийн хэрэгслийн жолоочийн хариуцлагыг заавал даатгах даатгалын тухай хууль”-ийн төслийг Хууль зүй, дотоод хэргийн яамтай хамтран шинэчлэн боловсруулж Засгийн газар, УИХ-д өргөн барих бэлтгэлийг ханган ажиллав. Энэхүү хуулийн төсөл батлагдсанаар автотээврийн хэрэгслээр зорчигч болон явган зорчигч зэрэг гуравдагч этгээдийн ашиг сонирхол хуулиар бүрэн хамгаалагдаж, автотээврийн осол гарсан тохиолдолд тэдгээрт даатгалын нөхөн төлбөр олгох эрх зүйн үндэслэл бүрдэх ач холбогдолтой болох юм.

Даатгалын үйл ажиллагаа нь иргэд, даатгуулагчдын даатгалын зах зээлд итгэх итгэл дээр суурилж байдаг онцлогтой тул иргэдийн энэхүү итгэлийг нэмэгдүүлж бататгах шаардлагын үүднээс 2010 онд даатгалын компанийн санхүүгийн чадавхийг сайжруулж, дүрмийн сангийн хөрөнгийн хэмжээг нь хоёр дахин нэмэгдүүлэх ажлыг зохион байгууллаа.

Түүнчлэн олон улсын даатгалын шинжээчдээс өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж, даатгалын багц дүрмийг сайжруулах зорилгоор даатгалын 1 журам шинээр, 4 журам, заавар, аргачлалыг шинэчлэн батлуулах ажлыг хийж, хэрэгжилтийг нь хангуулж ажиллалаа.

Даатгалын үйл ажиллагааг зохицуулах “Ердийн даатгалын нөөц сан бүрдүүлэх, зарцуулах, түүнд хяналт тавих журам батлах тухай журам”, “Ердийн даатгалын компанийн хөрөнгийн байршил, хөрөнгө оруулалт, түүнд тавигдах шаардлага”, “Даатгагчийн хөрөнгийг тусгаарлан байршуулах, түүний зарцуулалтад хяналт тавих журам”, “Тохиромжтой этгээдийг тодорхойлох заавар”, “Ердийн даатгал, давхар даатгалын болон даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн журам” зэрэг журмуудыг шинээр болон шинэчлэн, эсхүл нэмэлт өөрчлөлт оруулан баталлаа.

Тайлант онд шинэчлэн батлагдсан даатгалын журам, зааврыг дагаж мөрдүүлснээр даатгагч болон даатгалын мэргэжлийн оролцогч нарын үйл ажиллагааны зохицуулалт нь олон улсын даатгалын жишиг стандартад нийцэх нөхцөл шаардлага хангагдаж, Монгол Улсын Даатгалын тухай хуулинд заасан даатгалын зохицуулалтын багц дүрэм бүрэн боловсруулагдаж дууссан болно.

“Даатгалын компанийн засаглалын кодекс”-ыг батлан гаргаж хэрэгжүүлэх ажлыг эхлүүлсэн нь тайлант онд хийсэн томоохон ажлуудын нэг юм.

2010 оныг “Бизнесийн орчны шинэтгэлийн жил” болгон зарласан зорилтот ажлын хүрээнд Монголын даатгагчдын холбооноос тавьсан хүсэлтийг судалж даатгалын төлөөлөгчдөөс төвлөрүүлэх зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээг 2 дахин бууруулах арга хэмжээг авсан нь даатгалын компаниудын үйл ажиллагааг дэмжсэн ажил боллоо.

## **4.3. Даатгалын талаарх хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, хяналт шалгалт хийх ажлын талаар**

Тайлант онд даатгалын зах зээлд оролцогч ердийн даатгалын 15 компани, урт хугацааны даатгалын 1 компани, даатгалын зуучлагч 8, даатгалын хохирол үнэлэгч 6 компанийн санхүү, даатгалын үйл ажиллагааны тайланг улирал бүр хүлээн авч, дүн шинжилгээ хийж нэгтгэн, зайнаас тавих хяналтыг хэрэгжүүлсэн.

Хорооноос дотоодын даатгалын зах зээлийг санхүүгийн эрсдэлээс хамгаалж тогтворжуулах бодлогын арга хэмжээнүүдийг хэрэгжүүлж ажилласны үр дүнд даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий даатгагч нарын төлбөрийн чадварын шалгуур үзүүлэлт үндсэндээ бүрэн хангагдаж ирлээ.

Тайлант хугацаанд даатгалын зах зээлд оролцогчдын тусгай зөвшөөрлийг зохицуулах, даатгалын салбарын дэд бүтцийг хөгжүүлэх ажлын хүрээнд 1 компанид ердийн даатгалын, 4 компанид даатгалын зуучлагчийн, 4 компанид даатгалын хохирол үнэлэгчийн үйл ажиллагаа эрхлэх

тусгай зөвшөөрөл шинээр олгож, 2 компанид даатгалын нэмэлт хэлбэрээр зөвшөөрөл олгох, 14 компанид дүрмийн сангийн хэмжээ, хувь нийлүүлэгчдийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах болон 11 компанид эрх бүхий албан тушаалтныг томилохыг зөвшөөрөх, 2 иргэнд даатгалын актуарчийн эрх олгох, 2 даатгалын компани нэгдэхийг зөвшөөрөх, 2 даатгагчийн тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон байна.

Даатгалын салбарын удирдах ажилтны зөвлөлгөөнийг зохион явуулж, дотоодын даатгалын зах зээлд тохиолдож буй хүндрэл бэрхшээл болон түүнийг давж гарах арга замын тухай даатгалын салбарын хэмжээнд санал солилцож, даатгалын зах зээлд оролцогчдын хууль ёсны эрх ашгийг хамгаалахад чигэлсэн арга хэмжээний талаар тогтож ярилцсан нь үр дүнтэй болсон.

Иргэд, даатгуулагчдын эрх ашиг зөрчигдсэн, даатгалын нөхөн төлбөр олголтын асуудлаар Хороонд хандаж 18 өргөдөл, гомдол ирсэнийг барагдуулсан. Энэ тоог өнгөрсөн онд 72 өргөдөл гомдол ирүүлж байсантай харьцуулахад ихээхэн цөөрсөн бөгөөд даатгалын компаниуд Хорооноос тавьсан шаардлагын дагуу даатгуулагчдын эрх ашгийг зөрчих явдал буурсантай холбон үзэж болох юм.

Даатгалын салбарыг хөгжүүлэх дунд хугацааны хөтөлбөрийн төслийг боловсруулж, даатгалын зах зээлд оролцогч мэргэжлийн байгууллагын ажилтнуудын оролцоотой дугуй ширээний ярилцлагыг зохион байгуулж хэлэлцүүлсэн.

Хороо нь даатгалын зах зээлийн эрх зүйн зохицуулалт, даатгалын компаниудын санхүүгийн чадвар болон даатгалын салбарын хөгжлийн нэгдсэн үзүүлэлтүүдийн талаар лавлагаа өгч, даатгалын зөвлөх үйлчилгээ үзүүлж ирлээ. Энэ нь даатгалын компани болон харилцагч иргэд, байгууллагуудын ашиг сонирхолыг хүндэтгэх, даатгалын зах зээлийн хөгжлийн өнөөгийн байдлын талаарх мэдээ, мэдээллээр үйлчлэх, тэдний хууль ёсны эрх ашгийг хамгаалах, улмаар даатгалын болон санхүүгийн зах зээлийн талаарх мэдээллийн ил тод байдлыг хангахад зохих тус нэмэр болсон.

Тайлант хугацаанд нийт 17 удаа даатгалын байгууллагын санхүү, даатгалын үйл ажиллагаанд газар дээрх хяналт шалгалт, 12 удаа төлөвлөгөөт бус болон хэсэгчилсэн шалгалтыг тус тус гүйцэтгэж илэрсэн зөрчил дутагдлыг шуурхай арилгуулах талаар хугацаатай үүрэг даалгаврыг өгч, биелэлтийг хангуулах ажлыг зохион байгуулсан. Энэ ажлын хүрээнд даатгалын тухай хууль тогтоомжийг зөрчсөн байгууллага, холбогдох этгээдүүдэд гаргасан зөрчил дутагдалтай нь холбогдуулан хуульд заасан торгуулийг ногдуулж, бүрэн төлүүлэх арга хэмжээг авлаа.

Тайлант хугацаанд газар дээрх шалгалтаар илэрсэн санхүүгийн буруутай болон даатгалын алдаатай үйл ажиллагаа, зөрчил, дутагдалтай холбогдуулан даатгалын компаниудад нийт 10,5 сая төгрөгийн торгуулийг хүлээлгэж, орлогыг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

Даатгалын байгууллагуудаас ирүүлсэн хүсэлтийг нь үндэслэн даатгалын зах зээл дээр үйл ажиллагаа явуулаагүй 103 даатгалын төлөөлөгчдийн тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох арга хэмжээ авлаа.

Даатгалын байгууллагуудын санхүү, даатгалын үйл ажиллагааны тайланд дүн шинжилгээ хийж, зайны хяналтын ажлыг тогтмол хэрэгжүүлж, тайлангийн хариуг хүргүүлж ажилласан нь даатгалын зах зээлийн санхүүгийн тогтвортой байдлыг хангахад чигэлсэн зохицуулалтын бодлогыг хэрэгжүүлэх, улмаар даатгалын салбарын дүр зургийг үнэн бодит байдлаар гаргаж харуулах ажлын үндэслэл болж ирлээ.

Тайлант онд Банкны тухай хуулийн шинэчилсэн найруулга батлагдсантай холбогдож банкуудын оролцоотой даатгалын зуучлагч компаниуд бий болох, банк болон даатгалын байгууллагуудын хоорондын уялдаа холбоо гүнзгийрэх чиг хандлага харагдаж байгаа тул цаашид даатгалын салбарт гарч болзошгүй санхүүгийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэхэд анхаарч даатгалын компани холбогдох арилжааны банкны үйл ажиллагаанд нэгдсэн иж бүрэн хяналт шалгалтыг хийх шаардлага урган гарч байна.

#### **4.4. Даатгалын зах зээлийг сурталчлах, даатгуулагчдын санхүүгийн боловсролыг дээшлүүлэх ажлын талаар**

Монгол Улсын нийт хүн амын дөрөвний нэг нь ямар нэг даатгалын гэрээнд шууд болон шууд бусаар хамрагдаж байгаа гэсэн судалгаа байдаг. Энэ нь нэг талаас хүн амын орлогын мөнгөн хуримтлал доогуур байгаатай, нөгөө талаар иргэд даатгалын ач холбогдлыг бүрэн ойлгож чадаагүйтэй холбоотой доогуур үзүүлэлт юм. Иймд иргэдэд даатгалын ач холбогдлыг тайлбарлан ойлгуулах, амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгө, хариуцлагын учирч болзошгүй эрсдэлээс даатгуулагчдыг хамгаалах ажлыг нэмэгдүүлэх зорилгоор даатгалын зах зээлийн талаарх мэдээ, мэдээллийг бүх нийтэд ил тод болгож сонин хэвлэл, олон нийтийн радио, телевизийн хөтөлбөр болон Хорооны вэб хуудсаар дамжуулан түргэн шуурхай хүргэх, даатгуулагч иргэд, байгууллагуудад зөвлөх үйлчилгээ үзүүлэх, даатгалын зах зээлд оролцогчдыг тусалж дэмжих ажлуудыг хийж гүйцэтгэсэн байна.

2010 онд иргэдэд зориулан даатгалын үйлчилгээний ач холбогдол, ердийн болон урт хугацааны даатгалын бүтээгдэхүүний онцлог, ялгаа, даатгалын салбарын хөгжлийн өнөөгийн байдал, цаашдын чиг хандлагын талаар төвийн болон орон нутгийн радио, телевизэд нийт 15 удаа сурвалжлага, шууд ярилцлага өгч, өдөр тутмын сонинд 20 удаа даатгалын талаарх мэдээ, мэдээлэл нийтлүүлж олны хүртээл болголоо.

Иргэд үйлчлүүлэгчдэд даатгалын зах зээлд оролцогч мэргэжлийн байгууллагуудын санхүү, даатгалын үйл ажиллагаатай холбоотой мэдээг түргэн шуурхай хүргэх, мэдээллийг ил тод болгох үүднээс Хорооны вэб хуудсанд даатгалын компаниудын үйл ажиллагааны талаарх сарын мэдээ, санхүүгийн улирлын тайлан тэнцэл, даатгалын салбарын улирлын болон жилийн эцсийн нэгдсэн танилцуулгыг бүрэн эхээр нь байрлуулж байгаа бөгөөд даатгалын бүх компаниуд жилийн эцсийн аудит хийлгэсэн санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүдээ сонинд хэвлүүлж олон нийтэд хүргэсэн байна.

2010 онд даатгалын салбарын эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох чиглэлээр Хорооноос авч хэрэгжүүлсэн бодлогын арга хэмжээ болон гаргасан шийдвэр, баталж мөрдүүлсэн журам, заавар, түүнчлэн даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан даатгагч, тэдгээрийн салбар, даатгалын төлөөлөгч, даатгалын зуучлагч, даатгалын хохирол үнэлэгч болон даатгалын актуарч, даатгалын байгууллагын санхүүгийн тайланд аудит хийх эрх авсан аудиторчуудын талаарх 22 мэдээллийг Хорооны вэб хуудсаар дамжуулан олон нийтэд хүргэж, байгууллага, иргэдэд лавлагаа, тодорхойлолтыг албан бичгээр нийт 88 удаа гаргаж өгсөн байна.

2010 оны 11 дүгээр сард Монгол Улсад даатгалын байгууллага үүсч хөгжсөний 76 жилийн ойг тохиолдуулан Монголын даатгагчдын холбоотой хамтран даатгалын өдөрлөг, спортын уралдаан тэмцээнүүдийг зохион явууллаа. Энэ үеэр иргэдийн даатгалын талаарх мэдлэг, боловсролыг дээшлүүлэх зорилгоор даатгалын хөгжлийн түүх, даатгалын зах зээлийн өнөөгийн байдал, цаашдын зорилт зэрэг сэдвүүдээр телевизээр даатгалын ач холбогдол, даатгалын салбарын тулгамдсан асуудлууд, шинээр нэвтэрч байгаа бичил даатгал болон малын индексжүүлсэн даатгалын бүтээгдэхүүн үйлчилгээний талаарх мэдээллийг хүргэсэн.

Тайлант онд даатгалын салбарын дэд бүтцийг хөгжүүлж даатгалын зах зээлд оролцогч мэргэжлийн байгууллагуудын боловсон хүчний мэргэшил, чадавхийг дээшлүүлэхэд онцгойлон анхаарч, даатгалын талаар төрөлжсөн сургалт, семинарыг төлөвлөн зохион байгууллаа

Хороо нь Иргэд, даатгуулагчдаас даатгалын зах зээлд итгэх итгэлийг бататгах зорилтыг хэрэгжүүлэн даатгалын компаниудын хөрөнгийн хэмжээ, санхүүгийн чадавхийг нь бэхжүүлэх тал дээр ихээхэн анхаарч “Даатгалын тухай хууль”-д нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төсөл УИХ-аар батлагдсантай холбогдуулан даатгалын байгууллагын дүрмийн сангийн доод хэмжээг 2010 онд хоёр дахин нэмэгдүүлэх тухай Хорооны шийдвэрийг гарган мөрдөж байна.

Тайлант хугацаанд шинэчлэн батлагдсан даатгалын журам, зааврыг дагаж мөрдүүлснээр ердийн болон урт хугацааны даатгагч, даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагааг олон улсын даатгалын зах зээлийн жишиг стандартад нийцүүлэх нөхцөл шаардлага бүрэн хангагдаж,



даатгалын талаарх хууль тогтоомжийг хэрэгжүүлэх эрх зүйн орчин боловсронгуй болж сайжирч байгааг дурдахад таатай байна.

## **ТАВ. ХОРООНЫ ЗОХИЦУУЛАЛТАД ХАМААРАХ БУСАД АЖЛЫН ТАЛААР**

**5.1.** Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай болон Валютын зохицуулалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль батлагдсантай холбогдуулан Монгол улсын нутаг дэвсгэр дээр үйл ажиллагаа явуулж буй банкнаас бусад хуулийн этгээд, иргэдийн гүйцэтгэж буй төлбөр тооцооны хяналтын асуудал Хорооны зохицуулалтын үйлчилгээнд хүрээнд хамрагдах байгууллагуудад хуулийн хэрэгжилтийн хяналт тавих зохицуулалтын бодлогыг тодорхойлох, дагаж мөрдөх ажлыг эрчимжүүлэхэд чиглэн ажиллалаа.

Хуулийн хэрэгжилтийг хангуулах зорилгоор хууль зөрчсөн аливаа үйлдлийг таслан зогсоох зорилго бүхий Хорооны мэдээллийн үтсыг ажиллуулж, иргэдээс мэдээлэл авах ажлын хүрээнд 2010 онд нийт 19 иргэдээс мэдээлэл ирсний дагуу холбогдох хяналт шалгалтыг хийж арга хэмжээ авсан.

Хуулийн хэрэгжилтийг хангуулах чиглэлээр аж ахуй нэгжүүдийн үйл ажиллагаанд үзлэг хийх тухай батлагдсан удирдамжийн дагуу 2010 оны 5 дугаар сарын 05-ны өдрөөс 5 дугаар сарын 11-ний өдрүүдэд Үлэмж ХХК, Эко констракшн ХХК, Талст дэлгүүр, Метро молл дэлгүүр /ЗСНБ ХХК/, Сант сургууль, Баяр констракшн ХХК зэрэг хуулийн этгээдүүд хийж гүйцэтгэж, ЗСНБ ХХК, Үлэмж ХХК, Талст дэлгүүр, Эко констракшн ХХК зэрэгт Улсын байцаагчийн албан шаардлага хүргүүлсэн.

Мөн 2010 оны 6 дугаар сарын 21-ний өдрөөс 7 дугаар сарын 01-ний өдрүүдэд Скайтел ХХК, Жи-Мобайл ХХК, Юнител ХХК, Мобиком ХХК, Аэромонголиа ХХК, Изинис эйрвэйз ХХК, Кореан эйрлайнз /Улаанбаатар хот дахь төлөөлөгчийн газар/, Эйрчайна /Улаанбаатар хот дахь төлөөлөгчийн газар/, Аэрофлот /Улаанбаатар хот дахь төлөөлөгчийн газар/, Эйр маркет ХХК, Наран трейвэл ХХК, Эйр линк ХХК, Ай Эй Ти ХХК, Эйси жэт ХХК, Эйр нетворк ХХК, Амудас монголиа ХХК, Мон эйр түр ХХК, Стар зон ХХК, Эйр транс ХХК, Эйр тиккет ХХК-уудад газар дээрх үзлэгийн хийж гүйцэтгэсэн.

Түүнчлэн өмнөх шалгалтад хамрагдсан 12 аж ахуй нэгжийн санхүүгийн үйл ажиллагаанд хэсэгчлэн газар дээрх үзлэгийг 2010 оны 9 дүгээр сарын 06-17-ны өдрүүдэд дахин хийсэн. Тайлант онд нийт 40 аж ахуйн нэгжид энэ хууль тогтоомжийн хэрэгжилтийг шалгасан байна.

Хяналт шалгалтаар илэрсэн зөрчилд 4 хуулийн этгээдэд улсын байцаагчийн албан шаардлага тавьж, ноцтой зөрчсөн 1 хуулийн этгээдэд 2,160.0 мянган төгрөгийн захиргааны шийтгэл ногдуулсан байна.

**5.2.** Валют солих цэгийг Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн хүрээнд үйл ажиллагааг явуулахаар зохицуулж, нөхцөл шаардлагыг хангасан 46 хуулийн этгээдэд зөвхөн гадаад валютын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгосоны үр дүнд санхүүгийн болон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийн тайлан тушаалтын ирц нэмэгдэж, валютын гүйлгээний мэдээг улирал бүр нэгтгэн, Хорооны удирдлагад танилцуулж, шаардлагатай мэдээллийг Монголбанкинд хүргүүлж байна. Түүнчлэн газар дээрх шалгалт, үзлэгт хамруулж, үүрэг даалгавар өгч, хуулийн дагуу холбогдох арга хэмжээг авч ажилласны үр дүнд гарч буй зөрчлийн хэмжээ эрс буурч байна.

**5.3.** Хорооны зүгээс шинэ тутам үүсч буй харилцааг дэмжиж, шинэ бүтээгдэхүүн зах зээлд нэвтрүүлэх чиглэлээр онцгойлон анхаарч ажиллаа. Хөрөнгийн зах зээлд хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны зах зээлийг бий болгох, уг харилцааны эрх зүйн орчныг бий болгох чиглэлээр идэвхи санаачлагатай ажилласны дүнд 2009 оны 7 дугаар сарын 09-ний өдөр Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны тухай хуулийг, 2010 оны 04 дүгээр сарын 23-ны өдөр Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийг тус тус Улсын Их Хурлаар батлууллаа. Цаашид энэ хуулийг хэрэгжүүлэхэд шаардлагатай холбогдох дүрэм журмыг боловсруулан гаргах, боловсронгуй болгоход анхааран ажиллана.

**5.4.** УИХ-ын 2010 оны 20 дугаар тогтоолоор Санхүүгийн зохицуулах хороонд “Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаастай холбоотойгоор зэрэглэл тогтоох үйл ажиллагаа эрхлэхтэй холбогдсон түр журам тогтоон мөрдүүлэх” гэж үүрэг болгосны дагуу компанийн зээлжих эрхийн зэрэглэл тогтоох ерөнхий аргачлалын төслийг олон улсын жишиг өөрийн орны онцлогт нийцүүлэн “Зэрэглэл тогтоох эрх олгох, үйл ажиллагааг бүртгэх журам”-ыг батлан мөрдөж байна.

**5.5.** Засгийн газраас 2010 оныг “Бизнесийн орчны шинэтгэлийн жил” болгон зарлаж үйл ажиллагааны төлөвлөгөө гарган хэрэгжүүлж ажилласан бөгөөд Хорооны шууд хариуцан гүйцэтгэх 13 ажил төлөвлөгдсөнөөс 11 ажил нь бүрэн биелсэн. Үлдсэн 2 ажлыг 2011 онд бүрэн гүйцэд хэрэгжүүлж дуусгана. Компанийн засаглалын хөтөлбөр, Компанийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, Компанийн зээлжих зэрэглэлийн ерөнхий аргачлал, Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл гээд бизнесийн орчны шинэтгэлийн жилийн зорилго зорилтыг дэмжсэн бодлогын чанартай олон бичиг баримтыг боловсруулсан.

## **ЗУРГАА. ОЛОН УЛСЫН БОЛООД БУС НУТГИЙН БАЙГУУЛЛАГУУДАЙ ХАМТЫН АЖИЛЛАГААГ ХӨГЖҮҮЛЭХ, БЭХЖҮҮЛЭХ ТАЛААР**

Хороо нь тайлант онд гадаад хамтын ажиллагааны хувьд уламжлалт харилцаагаа өргөжүүлэхийн зэрэгцээ хоёр талын хамтын ажиллагааг хөгжүүлэх санал, санаачлагыг дэмжиж, дараахь ажлуудыг хийж гүйцэтгэлээ.

**6.1.** Хороо 2009 онд Үнэт цаасны холбоодын олон улсын байгууллага (IOSCO)-ын Санамж бичгийн “Б” хавсралтад нэгдэн орсныг бататган “А” хавсралтад нэгдэн орохоор зорилт тавин ажиллаж байна.

Уг Санамж бичиг нь үнэт цаас, үүсмэл үнэт цаасны тухай хуулийг зөрчихтэй тэмцэхэд ач холбогдол бүхий хил дамнасан хамтын ажиллагааны олон улсын жишгийг тогтоох зорилготой болно. Хэрэв СЗХ нь “А” хавсралтад тавьсан шаардлагуудыг хангаж санамж бичигт бүрэн нэгдэн орж чадвал бусад санамж бичигт нэгдсэн улс орнуудын үнэт цаасны эрх бүхий байгууллагуудтай үнэт цаасны үйл ажиллагаатай холбоотой бүхий л мэдээллийг солилцох, хамтран ажиллах, зөвлөлдөх бүрэн эрхтэй болж нэгдсэн ойлголтод хүрч олон улсын жишигт хүрсэн үнэт цаасны эрх зүйн орчинтой болоход өндөр ач холбогдолтой юм.

**6.2.** Даатгалын хянан шалгагчдын Олон Улсын Холбоо /IAIS/-ны санамж бичигт нэгдэн орох ажлыг хэрэгжүүлэхээр ажиллаж байна. Энэ чиглэлд Даатгалын хянан шалгагчдын Олон Улсын Холбооны санамж бичигт нэгдэн орох бэлтгэл ажлыг хангах үүднээс, тус байгууллагад хандан хуулийн тайлбар хэрхэн хийх талаар асуулгыг 5-р сард хүргүүлсэн. Улмаар Даатгалын хянан шалгагчдын Олон Улсын Холбооны санамж бичигт нэгдэн ороход шаардлагатай хуулийн тайлбарыг Эрх зүйн хэлтэстэй хамтран боловсруулж, санамж бичгийн асуулгуудын хариулыг англи хэлнээ орчуулан 8-р сард хүргүүлэн, тус байгууллагатай дээрх санамж бичгийг байгуулахаар бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.

**6.3.** Германы техникийн хамтын ажиллагааны нийгэмлэг (GTZ) –тэй уламжлалт ажлын шугамаар тогтсон харилцааг дэмжих, санхүүгийн зах зээлийн эрх зүйн орчныг боловсронгуй болгох ажлын хүрээнд Германы техник хамтын ажиллагааны нийгэмлэгийн Олон улсын цагаачлал болон хөгжлийн төв (CIM)-өөс Үнэт цаасны газарт олон улсын зөвлөх мэргэжилтэн авч ажиллуулах тухай хүсэлтийг холбогдох анкетийн хамт ПТХАН-т хүргүүлээд байна.

Монгол Улсад хөрөнгийн зах зээлийн чиглэлээр мэргэшсэн нарийн мэргэжлийн боловсон хүчин хомс байгаа учир мэргэшсэн мэргэжилтнүүдийг урьж ажиллуулах чухал шаардлагатай байгааг харгалзан Германы техник хамтын ажиллагааны нийгэмлэгийн Олон улсын цагаачлал болон хөгжлийн төв (CIM)-өөс Үнэт цаасны газарт олон улсын зөвлөх мэргэжилтэн авч ажиллуулах

тухай хүсэлтийг ГТХАН-т хүргүүлсэн. Үүний мөрөөр сонгон шалгаруулах ажил хийгдэж байна.

**6.4.** Санхүүгийн Үйлчилгээг Хүргэх Хамтын Нийгэмлэг (AFI) нь Германы техник хамтын ажиллагааны нийгэмлэгийн санаачилга болон Билл ба Мелинда Гейтсийн Сангийн (Bill & Melinda Gates Foundation) хөгжиж буй орнуудын бага орлоготой иргэдэд санхүүгийн дэмжлэг үзүүлэх зорилго бүхий Санхүүгийн Үйлчилгээг Хүргэх Хамтын Нийгэмлэг (AFI)-д тайлант оны 7 дугаар сард гишүүнээр элссэн.

Санхүүгийн Үйлчилгээг Хүргэх Хамтын Нийгэмлэг (AFI) нь Германы техник хамтын ажиллагааны нийгэмлэгийн санаачилга болон Бил ба Мелинда Гейтсийн Сангийн (Bill & Melinda Gates Foundation) санхүүжилт болон зохион байгуулалттайгаар үйл ажиллагаа эрхэлж, хөгжиж буй орнуудын бага орлоготой иргэдэд санхүүгийн дэмжлэг үзүүлэх зорилготой байгууллага болно.

Энэ байгууллагад гишүүнээр элссэнээр санхүүгийн цогц мэдлэгийг харилцан солилцоход санхүү, техникийн болон ложистикийн тусламж дэмжлэг авах, санхүүгийн шинэ санаачлага бүхий цогц бодлогыг хөгжүүлэн хэрэгжүүлэхэд туслах зорилготой дунд болон урт хугацааны буцалтгүй тусламж авах, амжилттай хэрэгжсэн санхүүгийн бодлогыг шийдэхэд ач холбогдол бүхий судалгаа, ололтүүдтэй танилцах, цаашилбал AFI-аас жил бүр зохион байгуулдаг Дэлхийн болон бүсийн бодогын хурал, семинар, ажлын хэсгийн ба сургалт, солилцооны үйл ажиллагаанд оролцох зэрэг олон чухал давуу талтай болж байгаа юм.

Тус байгууллагын гишүүн болсноор Бил ба Мелинда Гейтсийн Сан(Bill & Melinda Gates Foundation)-аас санхүүгийн дэмжлэг авч нэн ялангуяа бичил санхүүгийн чиглэлээр төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх боломж нээгдэв. Үүний үр дүнд Санхүүгийн Үйлчилгээг Хүргэх Хамтын Нийгэмлэг (AFI)-тай хамтран Хөдөлгөөнт банкны /mobile banking/ чиглэлээр мэдээлэл солилцох төсөл хэрэгжүүлэхээр 2011 оны 3-р сард эцэслэн тохирсон.

**6.5.** Японы Олон Улсын Хамтын ажиллагааны байгууллага /JICA/-аас зарласан Япон Улсын Засгийн газраас 2011 онд төрийн байгууллагын чадавхийг дээшлүүлэх хэрэгжүүлэх төсөлд үнэт цаасны салбарын мэргэжлийн оролцогчид болон хөрөнгө оруулагчдын мэргэжлийн боловсролыг сайжруулах чиглэлээр “Санхүүгийн салбарын боловсрол” төслийн саналыг боловсруулж Сангийн яам болон Монгол дахь ЖАЙКА-гийн төлөөлөгчийн газарт хүргүүлээд байна. Улам бүр хөгжиж буй хөрөнгийн зах зээл дээрх мэргэжлийн оролцогчид болон Хорооны боловсон хүчин, мөн хөрөнгө оруулагчдын мэргэжлийн боловсролыг сайжруулах хэрэгцээ шаардлагыг үндэслэн энэхүү төслийг боловсруулсан.

**6.6.** Люксембургийн Хөгжлийн Агентлагаас хэргжүүлэх СЗХ-ны чадавхийг сайжруулах, Санхүүгийн сургалтын төв байгуулах төслийг эхлүүлэх бэлтгэл ажлыг хангах ажлын хүрээнд Зөвлөх ажилтан тус Хороон дээр томилогдон ажиллаж байна. Энэ төсөл хэрэгжсэнээр СЗХ-ны хүний нөөцийг бэхжүүлэх талаар холбогдох арга хэмжээг авч, мастерын болон бакалаврын сургалтанд тус хорооны удирдах болон мэргэжлийн ажилтнуудыг сургах, СЗХ-ны дэргэд Санхүүгийн боловсролын сургалтын нэгдсэн төвийг байгуулах, техник тоног төхөөрөмжөөр хангах, сургалтын загвар, арга зүйг боловсруулах, Санхүүгийн зах зээлийн мэргэжлийн оролцогчдод зориулан сургалт, семинар зохион байгуулах зэрэг ажлыг гүйцэтгэх боломжтой болно.

**6.7.** БНСУ-ын Санхүүгийн Хяналт Шалгалтын Алба (FSS)-тай, Гонконгийн Үнэт цаасны хороотой байгуулах харилцан ойлголцлын санамж бичиг зурах ажлыг тус тус зохион байгуулах, Польш улсын Санхүүгийн хяналт шалгалтын агентлагтай (PFSA) харилцан ойлголцлын санамж бичиг зурах ажлын бэлтгэл ажлыг хангах, БНХАУ-ын Үнэт цаасны зохицуулах хороо(CSRC)-той байгуулсан хоёр талын хамтын ажиллагааны санамж бичгийн хэрэгжилтийг хангах зэрэг өмнөх жилүүдэд хийгдэж байсан ажлыг үр дүнтэй үргэлжүүлэхээр ихээхэн чармайлт гарган ажиллалаа.

**6.8.** Хадгаламж, зээлийн хоршоодын чадавхийг сайжруулах төслийг санхүүжүүлж өгөх тухай хүсэлтийг АХБ-нд хүргүүлж, Япон Улсын Ядуурлыг бууруулах буцалтгүй тусламжийн сангаас ядуу

буурай иргэдэд чиглэсэн санхүүгийн үйлчилгээний төслийн харилцан ойлгоцлийн санамж бичигт СЗХ, Сангийн яам, АХБ-ны төлөөлөл гарын үсэг зурж 2.5 сая долларын тэтгэлэгийг Японы улсын Засгийн газар олгохоор шийдвэрлэлээ.

**6.9.** АХБ-наас санхүүжүүлж байгаа “Хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэх төсөл”/ТА 7112 МОН-ийн хэрэгжилтийн хүрээнд Улаанбаатар хотын дүүргүүдэд, дөрвөн аймгийн төвд үнэт цаасны тухай хуулийн төслийг сурталчлах, хөрөнгийн зах зээлийн талаарх боловсролыг нэмэгдүүлэх сургалт семинарыг зохион байгуулсан.

**6.10.** АХБ-ны Зүүн Өмнөд Азийн Газрын Санхүүгийн салбар, Төрийн удирдлага, бүсийн хамтын ажиллагааны хэлтэстэй хамтран “Монгол улс дахь Санхүүгийн салбарын үнэлгээ, хөрөнгийн зах зээлийн шнэчлэл” сэдэвт семинарыг зохион байгуулав.

## **ДОЛОО. ХОРООНЫ 2010 ОНЫ ТӨСӨВ, САНХҮҮГИЙН ТОВЧ ТАЙЛАН**

Монгол Улсын Их Хурлаас Санхүүгийн Зохицуулах Хорооны 2010 оны тодотгосон төсвөөр урсгал зардлыг 911.6 сая.төг – өөр баталснаас 441.0 сая.төг буюу 48,4 % - ийг улсын төсвийн санхүүжилтын эх үүсвэрээс , 470.6 сая.төг буюу 51,6 % - ийг үндсэн үйл ажиллагааны орлого буюу үйлчилгээний хураамжийн орлогын эх үүсвэрээс тус тус санхүүжүүлэхээр баталсан.

2010 онд улсын төсвийн хөрөнгө оруулалт болон олон улсын зээл, тусламжийн зардал төлөвлөгдөж батлагдаагүй болно.

### **7.1. Үндсэн үйл ажиллагааны орлогын эх үүсвэрийн талаар**

Хорооноос батлагдсан тусгай зөвшөөрөл эзэмшигчдээс төвлөрүүлэх зохицуулалт үйлчилгээний хөлс тогтоох журмуудын дагуу Хорооны үндсэн үйл ажиллагааны төсвийн орлогын эх үүсвэрийг бүрдүүлсэн бөгөөд тайлант онд 692.2 сая. төг – ийн зохицуулалт үйлчилгээний хураамжийг төвлөрүүлж, үүнээс үйл ажиллагааны санхүүжилтын дансанд 436.9 сая. төг тэгшитгэн үйл ажиллагааг санхүүжүүлсэн байна.

Үндсэн үйл ажиллагааны орлогыг нэр төрөл, үйлчилгээний чиглэл, эзлэх хувийн жингээр нь авч үзвэл: 26,6 % - ийг Даатгалын байгууллагын зохицуулалтын үйлчилгээний хураамж, 22,7 % - ийг Үнэт цаасны үйл ажиллагааны зохицуулалтын хураамж, 21,8 % - ийг ББСБ , ХЗХоршоод, 24,4 % - ийг ҮЦТТХТ, үнэт цаасны арилжааны үйл ажиллагааны зохицуулалтын үйлчилгээний хураамжаас тус тус бүрдсэн байна. Төсвийн урсгал санхүүжилтын орлогын эх үүсврээр 476.3 сая.төг санхүүжихээс 437.6 сая.төг – ийн санхүүжилт авч, 91.9 % - ийн гүйцэтгэлтэй гарлаа.

### **7.2. Үндсэн үйл ажиллагааны зардал санхүүжилтийн талаар**

Хорооны тайлант оны төсвийн урсгал зардал 977.6 сая. төг – өөр батлагдснаас гүйцэтгэлээр 904.7 сая.төг - д хүрч , төсвийн урсгал зардлыг 6.9 сая.төг буюу 0,8 % - иар хэмнэсэн байна.

Төсвийн урсгал зардлын гүйцэтгэлийн 49,0 % - ийг үндсэн цалин, 6,4 % - ийг унаа хоолны хөнгөлөлт, 6,4 % - ийг нэмэгдэл урамшуулал, 6,8 % - ийг ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл, 0,9 % - ийг бичиг хэргийн зардал, 1,4 % - ийг тээвэр шатахууны зардал, 7,9 % - ийг шуудан холбооны зардал, 1,6 % - ийг дотоодын албан томилолт, 2,1 % - ийг гадаад албан томилолт, 4,8 % - ийг сургалт сурталчилгааны зардал, 0,2 % - ийг урсгал засварын зардал, 1,1 % - ийг программ хангамжийн зардал, 2,8 % - ийг төлбөр хураамж болон бусад зардал, 0,1 % - ийг гадаад зочны зардал, 0,1 % - ийг биеийн тамир уралдаан тэмцээний зардал, 4,2 % - ийг нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардал, 3,8 % - ийг олон улсын байгууллагын гишүүний татвар тус тус эзэлж байна.